6	Хуулийн 15.2 заасан Төсвийн байгууллага төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлууд, гарсан үр дүн тоо, чанараар, нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулсан эсэх, тоолуурын тоо, гарсан үр дүн тоо, чанараар;	Хуулийн 15.2.6 дахь заалтын хүрээнд эрчим хүчний нөөц үүсгүүрийн хувьд бүрэн автомат 262, автомат бус 285 барилга, халаалтын төвийн нэгдсэн системд холбогдсон 470, бие даасан халаалттай 102; бусад байдлаар халаадаг 37 барилга байгаа бол төвийн нэгдсэн цэвэр бохир усны системд холбогдсон 319, зөөврийн устай 173, бие даасан усны системтэй 108 барилга байна.
7	Хуулийн 17 дугаар зүйл буюу Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;	Хуулийн 17.1.2 дахь заалтын хүрээнд Эрүүл мэндийн багц хуулиудад 2021 оноос нэмэлт өөрчлөлт орж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар эрүүл мэндийн сайдын багцад лавлагаа шатлалын 66 байгууллага, анхан шатны 332 байгууллага гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд шилжээд байна. Хуулийн 17.1.3 дахь заалтын хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд хоол үйлдвэрлэл, ариутгал халдваргүйтгэлийн үйлчилгээ, хог хаягдал тээвэрлэх үйлчилгээ, улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх, харуул хамгаалалтын үйлчилгээ, нормын хувцас зөөлөн эдлэл үйлдвэрлэх, урсгал засварын нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил болон жижиг дунд үйлдвэртэй гэрээ байгуулан бусдаар гүйцэтгүүлж байна. Мөн зарим лабораторийн шинжилгээ хийхтэй холбоотой тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн лабораторитой гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. 17.1.4 Эрүүл мэндийн байгууллагууд эмч эмнэлгийн ажилтны цалин хөлсийг Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр дамжуулан 100 хувь олгож байгаа бөгөөд

		2024 оноос эрүүл мэндийн тухай хуулийн 29.2, 29.5 дахь заалтын дагуу олгогддог тэтгэвэр тэтгэмжийг мөн дээрх программаар олгуулах ажлыг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн. Улсын төсвөөс 100 хувь санхүүждэг эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн яамны харьяа гүйцэтгэлээр санхүүждэг лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагууд буюу 63 байгууллага бүрэн нэвтрүүлээд байна. Сумын эрүүл мэндийн төвүүд ТАЦНС программаар нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг олгуулах ажлыг үе шаттайгаар нэвтрүүлж эхэлсэн бөгөөд 2025 оноос мөнгөн тэтгэмжийг ТАЦНС программаар бүрэн олгуулахтай холбоотойгоор бэлтгэл ажлыг базааж 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдөр аймаг нийслэлийн эрүүл мэндийн газар болон нэгдсэн эмнэлгийн хүний нөөц, цалингийн нягтлан бодогч нарт Сангийн яамнаас анхаарах асуудлын талаар сургалт, зөвлөгөөг цахимаар өгч ажилласан.
8	Хуулийн 20.2-т “Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод нээлттэй байршуулна” гэж заасны дагуу хэчнээн гүйцэтгэх захирал төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулсан, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод нээлттэй байршуулсан зэрэг болно.	Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшиж буй хамт олны төлөөллийг Эрүүл мэндийн сайдын баталсан удирдамжаар, харин Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/565 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн емчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн ТУЗ-д ажиллах олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгох журам”-ын дагуу олон нийтийн төлөөллийг moh.gov.mn сайтад ил тод нээлттэй байршуулан сонгон шалгаруулж, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 15.30-д заасны дагуу Эрүүл мэндийн сайд, аймаг, дүүргийн Засаг дарга нар батламжилж байна. 2024 оны 11 сарын байдлаар Улаанбаатар хотод 3 төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, 2 дүүргийн нэгдсэн эмнэлэг, орон нутгийн 6 эрүүл мэндийн байгууллагууд Төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.

МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД
Засгийн газрын VII байр, Энхтайваны өргөн чөлөө 51,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13340
Утас: 26 35 31, Факс: (976-11) 45 81 12,
Цахим шуудан: info@mod.gov.mn,
Цахим хуудас: www.mod.gov.mn

2024 11 05 № 14/4194

танай _____-ны № 05/2216-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Таны 2024 оны ХЭГ/2216 дугаар албан бичгийн дагуу Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг батлан хамгаалах салбарын хэмжээнд хангуулан ажилласан талаарх мэдэгдлийг хүргүүлж байна.

Хавсралт 3. хуудастай.

С.БЯМБАЦОГТ

13246018 97

Батлан хамгаалахын сайдын 2024 оны
11. дугаар сарын 21-ны өдрийн
1/4194 дугаар албан бичгийн хавсралт

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАН АЖИЛЛАСАН ТАЛААР

Д/д	Холбогдох асуудлууд	Тайлбар
1	Хуулийн 7.3-т "Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална" гэж заасны дагуу уг нийтлэг жишиг, батлагдсан эсэх, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгсэлд хэрхэн хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангасан талаар	Яамны батлагдсан бүтэц орон тоо, ажлын байрны талбайн хэмжээнд тохируулан өрөө доторх зохион байгуулалтыг хийж, албан тасалгааны тавилга, тоног төхөөрөмжийг байршуулан, албан хаагчдын ажиллах орчныг бүрдүүлэн ажилласан. Хуульд заасны дагуу төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгийн шинж чанартай худалдан авалтыг хийгээгүй болно.
2	Хуулийн 8.1, 8.2-т заасан төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон заалтын хэрэгжилтийн талаар	Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэсэн заалт салбарын үйл ажиллагаанд хамааралгүй болно.
3	Хуулийн 10.1-д Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, ... тогтооно" гэж заасны дагуу уг нийтлэг жишиг батлагдсан эсэх, төрийн болон орон нутгийн өмчийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсөнд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангасан талаар	Засгийн газраас баталсан Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээний дагуу цалин хөлсийг олгож, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.
4	Хуулийн 14 дүгээр зүйл буюу Цахим худалдан авалтын хэрэгжилтийн талаар	Худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт тавигдсан эм, эмнэлгийн хэрэгсэл бусад батлан хамгаалахын хэрэгцээт материал хэрэгслийн худалдан авалтыг цахим дэлгүүрээс худалдан авч хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. Цэргийн төв эмнэлэг 2022 онд 967,257.4 мянган төгрөгийн, 2023 онд 1,382,476.4 мянган төгрөгийн, 2024 онд 1,144,933.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, 259,106.0 мянган төгрөгийн хүнсний материал хэрэгсэл цахим дэлгүүрээс тус тус худалдан авсан. БХЯ 2024 онд 85,251.0

		мянган төгрөгийн компьютер, түүний дагалдах хэрэгслийг цахим дэлгүүрээс худалдан авсан.
5	Хуулийн 15 дугаар зүйл буюу Хэмнэлтийн бусад арга хэмжээний хэрэгжилтийн талаар	Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулж, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 95/260 дугаар тушаалаар батлсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ыг үндэслэн БХЯ, ЗХЖШ-ын албан ажлын, дуудлагын суудлын автомашины ашиглалтыг зохицуулах зорилгоор "Журам батлах тухай" Батлан хамгаалахын сайдын А/31 дүгээр тушаалыг батлуулж, дуудлага суудлын автомашиныг 08:00-17:30 хүртэл үйлчилгээнд гаргах ажлын цагаар өдөрт 40 километрийн лимиттэйгээр захиалгын дагуу гарган ажиллуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Орон нутагт ажиллах бүрэлдэхүүний унааны тоог хязгаарлах, нэгдсэн унаагаар зорчуулах, цэргийн анги, байгууллагуудад хийгдэх хяналт, шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу чиглэл бүрийг хамарсан байдлаар зохион байгуулан ажиллаж байна. БХЯ, ЗХЖШ, харьяа байгууллагууд бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор дотоод сүлжээг ашиглан албан бичиг, хэрэг хөтлөлтийг зохион байгуулж, төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө, бэлэг дурсгалын зүйлс худалдан аваагүй. Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 165,195.4 мянган төгрөгийн төсвийг хэмнэсэн.
6	Хуулийн 15.2-т заасан Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлууд, гарсан үр дүн тоо, чанараар, нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулсан эсэх, тоолуурын тоо, гарсан үр дүн тоо, чанараар	Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний дагуу шаардлагагүй тохиолдолд цахилгааныг унтраах, дулааны тоолуур байрлуулах, ялтсан бойлер суурилуулах зэрэг ажлуудыг хийсэн.
7	Хуулийн 20.2-т "Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон	Яамны харьяа Төрийн өмчит байгууллагуудын бүтэц орон тоо нууцад хамаарах тул цахим хуудсанд мэдээлэх боломжгүй.

	шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна"	

БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ

92

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД
Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Улаанбаатар хот, 15160
Утас: 51-265102 Факс: (976-11) 330780
Цахим шуудан: info@mddic.gov.mn
Цахим хуудас: www.mddic.gov.mn

2024.12.03 № 01/1057

танай 2024.11.14 -ны № ХЭГ/2216 -т

Г МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Танаас ирүүлсэн "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл ирүүлэх тухай" албан бичигтэй танилцаад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл хүргүүлж байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагаас гаргаж ирүүлсэн мэдээллийг хавсаргаж хүргүүлэв.

Хавсралт 12 хуудастай.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
Удирдлага
Сайд
Цэнд Баатархүү
2024-12-03 19:16:38

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

2024.11.27

№	Хуулийн	Хуулийн заалт	Хуулийн хэрэгжилт
1	7 дугаар зүйл.Албан тасалгаа	7.3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.	Монгол улсын Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын дагуу, Монгол улсын ерөнхий сайдын 2022 оны 12 дугаар захирамжаар Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Зүүн жигүүрийн 1-3 давхарт байрлаж байна. 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг баталснаар 10 орон нэмэгдсэн бөгөөд тайлант онд тавилга шинээр худалдан аваагүй байна.
2	8 дугаар зүйл.Дүрэмт хувцас	8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.	Тайлант хугацаанд байгууллагын хөрөнгөөр хөдөлмөр хамгааллын хувцас, дүрэмт хувцас худалдан аваагүй
		8.2.Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй.	
3	10 дугаар зүйл.Цалин хөлс, нэмэгдэл	10.1.Тил ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон	Тус яам нь Монгол улсын засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолыг мөрдлөг болгон цалин хөлсийг тогтоон ажилладаг.

4	14 дүгээр зүйл.Цахим худалдан авалт	14 дүгээр зүйл.Цахим худалдан авалт	2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 40 ширхэг "Оффис 365 лиценз худалдан авах" ажлыг цахим дэлгүүрээс худалдан авахаар захиалга нийтэлж, 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Инфосолюшн ХХК-тай гэрээ байгуулсан. Цахим дэлгүүрт байршсан бараа, ажил үйлчилгээг тендер худалдан авалт, болон шууд гэрээ худалдан авалт хийгээгүй.
5	15 дугаар зүйл.Хэм нэлтийн бусад арга хэмжээ	15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно	15.1.2 Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолоор яамны зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг 98 байхаар тогтоож, 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 44 дүгээр тогтоолоор "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг батлалсан. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн "Яамны зохион байгуулалтын бүтцийн албан тушаалын нэр, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/80 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын нэрс, ангилал зэрэглэлийг шинэчлэн батлалсан. Уг бүтцээр төрийн өндөр 2, улс төрийн 3, төрийн захиргааны 84, төрийн үйлчилгээний 9 албан тушаалын орон тоотой байна. 15.1.3 хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй 15.1.4 байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлээгүй 15.1.5.төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан аваагүй 15.1.6.их хэмжээгээр бараа, материал нөөцлөөгүй бөгөөд шаардлагагүй бараа материал худалдан аваагүй. 15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа хэрэглэж, архаг өвчний хөдөлмөрийн чадвар хэсэгчилсэн алдалт тогтоолгох

6	15 дугаар зүйл.Хэм нэлтийн бусад арга хэмжээ	15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана:	**15.2.2.**Тус яамны байрлаж буй Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ын байр нь халаалтын нэгдсэн системд холдбогдсон. **15.2.4.**бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх ажилласан. **15.2.5.**хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөр төлбөр үүсгээгүй **15.2.6.** Монгол улсын засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн төрийн зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоолын дагуу олгож байна.
7	17 дугаар зүйл.Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ	18 дугаар зүйл.Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ	хамаарахгүй
8	20 дугаар зүйл.Тайлагналт, ил тод байдал	20.2.Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон	хамаарахгүй

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

Самбуугийн гудамж, Бага тойруу 2, 6 дугаар хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14192
Утас: 26 03 05, Факс: (976-51) 26 03 10
Цахим шуудан: info@khurdan.gov.mn,
Цахим хуудас: www.khurdan.gov.mn

2024.11.28 № 01/435

танай _____-ны № _____-т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД


Тус газрын үйл ажиллагаатай холбоотой Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

ДАРГА Т. **П.БАТБААТАР**

15 [illegible]

D:A5: alban bichig 2024.docx



Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын
2024 оны 11 дүгээр сарын ... ны өдрийн
01/... дугаар албан бичгийн хавсралт

Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын хариуцсан асуудлын хүрээнд хамаарах Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл

2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр

№	Холбогдох заалт	Биелэлт
1	Хуулийн 7.3-т "Төрийн албан хаагчийн албан ажлын ерөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална" гэж заасны дагуу уг нийтлэг жишиг батлагдсан эсэх, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны ерөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгсэлд хэрхэн хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг ханган талаар;	Тус газар нь төрийн цахим үйлчилгээг тасралтгүй, хэвийн явуулах зорилгоор Сүхбаатар дүүргийн 6-р хороо, "Сити капитал" оффисын 4, 5 дугаар давхрын 558,2м^2 талбайг албан конторын зориулалтаар түрээсийн гэрээ байгуулан ашиглаж байна. Энэхүү албан контортод 45 албан хаагч ажилладаг бөгөөд удирдах албан хаагчийн ерөөний талбайн хэмжээ 24м^2 байхаас 12м^2-15м^2, дэс түшмэлийн албан тушаалын ангилалд хамаарах албан хаагчид 8м^2 талбай байхаас 4м^2-6м^2 талбай оногдож байна.
2	2. Хуулийн 8.1, 8.2-т заасан төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон заалтын хэрэгжилтийн талаар;	Тус газар нь Нийтийн мэдээллийн ил, тод байдлын тухай хуульд зааснаар хүн, хуулийн этгээдийн гаргасан үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, эрх бүхий байгууллагад шилжүүлж шийдвэрлүүлэх, хүн, хуулийн этгээдэд хариу мэдэгдэх ажлыг шуурхай зохион байгуулах, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, орон нутгийн хэмжээнд төрийн үйлчилгээг хүргэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах хүрээнд төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийг 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүрэг, 204 хороонд байгуулан операторын горимоор хүн, хуулийн этгээдэд хүргэн ажиллаж байна. Төрийн цахим үйлчилгээний асуудал эрхэлсэн байгууллагын хувьд иргэдтэй шууд харилцаж төрийн цахим үйлчилгээг хүргэдэг. Гэвч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1, 8.2-т зааснаар дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон нь үйлчилгээний ажилтнуудыг жигд хувцсаар хангаж, төрийн үйлчилгээний соёл, стандартыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна. Тус газар нь хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авааг үгүй болно.
3	Хуулийн 10.1-д "Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны	Тус газар нь нийт 174 **төрийн албан хаагчтай** бөгөөд үүнээс Төрийн захиргааны албан

	түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, ... тогтооно" гэж заасны дагуу уг нийтлэг жишиг батлагдсан эсэх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсөнд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангасан талаар;	тушаалын ангилалд хамаарах 9, төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд хамаарах 165 албан хаагч ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолоор батлагдсан цалингийн хэмжээг мөрдлөг болгон ажиллаж байна.
4	Хуулийн 14 дүгээр зүйл буюу Цахим худалдан авалтын хэрэгжилтийн талаар;	Тус газар нь Хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.Цахим дэлгүүрт байршсан барааг, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно, 14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана гэснийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
5	Хуулийн 15 дугаар зүйл буюу Хэмнэлтийн бусад арга хэмжээний хэрэгжилтийн талаар;	Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй холбоотой хориглосон заалтыг мөрдлөг болгон ажилласан. Мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй холбоотой хэмнэлт хийх зохицуулалтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
6	Хуулийн 15.2 заасан Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлууд, гарсан үр дүн тоо, чанараар, нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулсан эсэх, тоолуурын тоо, гарсан үр дүн тоо, чанараар;	Тус газар нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Агентлаг байгуулах тухай" 499 дүгээр тогтоолоор байгуулагдсан тул Төрийн хэмнэлтийн тухай хуулийн тус заалтыг тухай бүр мөрдлөг болгон ажиллаж байгаа болно.
7	Хуулийн 17 дугаар зүйл буюу Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар;	Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т заасан "төрийн зарим нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх" гэсэн зохицуулалтын хүрээнд Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 499 дүгээр тогтоолын хүрээнд тус газар нь төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулж төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд чанар, хүртээмжтэй хүргэх боломжийг бүрдүүлсэн.

		• Мөн Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд "Монголын цахилгаан холбоо" ХК, "Монгол шуудан" ХК-ийн салбар нэгжүүдээр төрийн цахим үйлчилгээг хүргэн ажиллах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. • Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд "Гэрэгэ" ХХК-ийн киоск машинаар дамжуулан төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэн ажиллаж байна. • Төрийн банк ХК-ийн иргэдэд үйлчилгээ үзүүлдэг киоск машинаар дамжуулан төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн. • Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг журмыг Засгийн газар батална гэж заасны дагуу төрийн үйлчилгээний асуудал хариуцсан байгууллагын хувьд төрийн үйлчилгээг тасралтгүй, хөвийн үргэлжлүүлэхэд төөрийн хэрэгсэл нэн шаардлагатай байна. Мөн тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт баталсан жагсаалтад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

100

И МОНГОЛ АКАДЕМИ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
Мэдээлэл технологийн үндэсний парк, Бага тойруу 49,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200

Утас: 77111197 Факс: 77111197
Цахим шуудан: info@ema.gov.mn
Цахим хуудас: www.ema.gov.mn

2024.11.25 №01/470

танай_____-ны №_____-т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгын дагуу хуулийн хэрэгжилтийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

И Монгол академи
Удирдлага
Захирал
Бавуужав Мягмарнаран
2024-11-25 18:22:41

"И-Монгол академи" УТҮГ-ын
2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн
01/470 тоот албан бичгийн хавсралт

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгын дагуу хүснэгтээр тайланг бэлтгэв.

№	Асуулга	Хэрэгжилт
1	Хуулийн 8.1, 8.2 төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон заалтын талаар	Тус газар нь дүрэмт хувцас худалдаж аваагүй бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.
2	Хуулийн 14 дүгээр зүйл буюу цахим худалдан авалтын талаар	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд цахимаар нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажиллаж байна.
3	Хуулийн 15 дугаар зүйлийн хэрэгжилтийн талаар	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хориглолтыг хэрэгжүүлэн, энэхүү заалттай гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллаж байна.
4	Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн хэрэгжилтийн талаар	Тус газар нь Мэдээлэл технологийн үндэсний паркийн 4 дүгээр давхрыг гэрээний үндсэн дээр түрээсэн ашиглаж байгаа бөгөөд цахилгааны тоолуурын заалтын дагуу холбогдох төлбөрийг сар бүр барагдуулдаг. Төрийн байгууллагын дотоод удирдлагын нэгдсэн систем ERP, албан бичиг солилцооны docx системийг ашиглан дээрх ERP систем ашиглан цахимаар албан бичиг илгээх, хүлээн авч, байгууллагын дотоод үйл ажиллагаатай бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг ERP систем, teams зэрэг цахим хэрэгслийг ашиглан бичгийн цаас, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх ажлыг дотооддоо зохион байгуулж байна.

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ
УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
34 дүгээр хороо, Сонгино хайрхан дүүрэг,Улаанбаатар хот, 18170
Утас: 70180092 Факс: 70180092
Цахим шуудан: info@datacenter.gov.mn
Цахим хуудас: datacenter.gov.mn

2024.11.29 № 01/382

танай _____-ны № _____-т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА П.АЛТАН-ОД ТАНАА

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн явцын талаарх мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

Үндэсний Дата Төв УТҮГ
Удирдлага
Захирал
Мөнхдорж Баттулга
2024-11-29 09:45:38

Төрийн хэмнэлттийн тухай хэрэгжилтийн талаар мэдээлэл

№	Хуулийн заалт	Асуулгын асуулт	Хэрэгжилтийн тайлбар
1	7.3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.	Хуулийн 7.3-т 7.3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална" гэж заасны дагуу уг нийтлэг жишиг батлагдсан эсэх, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгсэлд хэрхэн хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангасан талаар	Засгийн газрын хэрэгжүүлэх ажиллагаа
2	8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно. 8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.	Хуулийн 8.1, 8.2-т заасан төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглосон заалтын хэрэгжилтийн талаар;	Үндсэний дата төв УТҮГ-нь ажилтнууд дүрэмт хувцас өмсдөггүй бөгөөд төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцастай холбоотой худалдан авалт хийгээгүй болно.
3	10.1.Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.	Хуулийн 10.1-т .Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар тогтооно гэж заасны дагуу нийтлэг жишиг батлагдсан эсэх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсөд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангасан талаар	Засгийн газрын хэрэгжүүлэх ажиллагаа
4	14 дүгээр зүйл.Цахим худалдан авалт 14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. 14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ. 14.3.Төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ирүүлсэн хүсэлтэд үндэслэн холбогдох бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт оруулах арга хэмжээг тухай бүр хийж гүйцэтгэнэ. 14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно. 14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.	Хуулийн 14 дүгээр зүйл буюу Цахим худалдан авалтын хэрэгжилтийн талаар	2024 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цахим дэлгүүрээс (Могул сервис) 39,110.0 мянган төгрөгийн Power Bi Pro-g худалдан авсан байна.

5	15 дугаар зүйл.Хэмнэлтийн бусад арга хэмжээ 15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.1.Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэргүйгээр шинээр хараат болон охин компани байгуулах; 15.1.2.чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох; 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; 15.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх; 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах; 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашигтүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх; 15.1.7.байгууллагын төсвөөр соргуулуулах ундаа худалдан авах.	Хуулийн 15 дугаар зүйл буюу Хэмнэлтийн бусад арга хэмжээний хэрэгжилтийн талаар	Хэмнэлтийн хуулийн дагуу хориглосон арга хэмжээнд зардал гаргаагүй болно.
6	15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана: 15.2.1.байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;	Хуулийн 15.2 заасан Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цахилгаан дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх чигэлэлээр авч хэрэгжүүлсэн ажлууд гарсан үр дүн тоо, чанараар, нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулсан эсэх, тоолуурын тоо гарсан үр дүн тоо чанараар,	Байгууллагын ажлын онцлогоос шалтгаалан цахилгаан эрчим хүчний төлбөр хэмнэх боломжгүй бөгөөд цахилгааны төсөвлөгдсөн төсөвтөө багтаан өр төлбөр үүсгэлгүй ажиллаж байна.
7	17 дугаар зүйл.Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ 17.1.Засгийн газар хэмнэлтийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 17.1.1.чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх; 17.1.2.төр, олон нийтэд үзүүлж байгаа үйлчилгээний орлогоор өөрийгөө санхүүжүүлэх боломжтой төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газруудыг ах ахуйн тооцооны зарчмаар ажиллуулах, тухайн чиг үүргийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх; 17.1.3.төрийн зарим нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх; 17.1.4.төрийн байгууллагын орон тоо, цалин хөлсний төлөвлөлт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох; 17.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх	Хуулийн 17 дугаар зүйл буюу Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар	Засгийн газрын хэрэгжүүлэх ажиллагаа
8	20.2.Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.	Хуулийн 20.2-т "Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод нээлттэй байршуулсан талаар зэрэг болно	Засгийн газрын хэрэгжүүлэх ажиллагаа

РАДИО ТЕЛЕВИЗИЙН
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ
ҮЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
Амарсанаагийн гудамж, 17 дугаар хороо
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16069
Утас: 7511 2020, Факс: (976) 7019 9995,
Цахим шуудан: info@rtl.gov.mn

2024.11.27 № 01/266

танай _____-ны №_____-т

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД

Хариу хүргүүлэх тухай

"Төрийн хэмнэлтийн хууль"-ийн хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд дараах хэмнэлтүүдийг хийсэн. Үүнд:

1. "Төрийн хэмнэлтийн хууль"-ийн 7.3, Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын хүрээнд Төрийн албан хаагчийн ажлын унаа, өрөөний талбай, тавилга хэрэгслийн нийтлэг жишгийн хүрээнд байгууллагын хэрэгцээнд тавилга хэрэгсэл, компьютер 2015 оноос нэмж аваагүй хуучирсныг сэлбэн засаж үйл ажиллагаандаа хэрэглэдэг, бичиг хэргийн болон хувцасны өлгүүр (шүүгээ)-г албан хаагчид дундаа хэрэглэдэг, сэтгүүлийн ширээгүй, 3-4 албан хаагч 24м^2 өрөөнд хамт сууж байна.

2. Хуулийн 8.1, 8.2-т төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас ажлын хувцас аваагүй. Харин уг хуулийн заалтын 8.2-т заасан хориглоогүй, хамаарахгүй гэгдэх тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хуулийн 15.1-т заасан хэсэгт холбогдох инженер, техникийн албан хаагчдын мэргэшлийн үйл ажиллагаа явуулахад зайлшгүй шаардлагатай хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангаж, цөөн тооны хувцас хэрэгсэл авсан.

3. Хуулийн 10.1-д заасны дагуу "Цахим хөгжил, инновац, харилцаа, хөгжлийн сайдын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/56 дугаар тушаалаар батлсан бүтэц орон тоо болон " Радио телевизийн үндэсний сүлжээ" УТҮГ-ын захирлын 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/38 тоот тушаалаар бүтэц орон тоо, цалингийн жишгийн хүрээнд үйлчилгээний ажилтан 900,000-1,000,000 төгрөг, инженер техникийн ажилтнууд 1,200,000-1,400,000 төгрөг, удирдах албан тушаалтнууд 1,800,000-2,200,000 төгрөгийн цалинтай тус тус ажиллаж байна. Мөн нэг өдрийн хоол унааны зардал Улаанбаатарт 6,000, орон нутагт 5,500 төгрөгөөр тооцон олгож байгаа нь бусад ижил төстэй байгууллагын цалин болон хоол унааны зардалтай харьцуулахад 1-1,5 дахин бага байгаа юм.

4. Хуулийн 14 дүгээр зүйл Цахим худалдан авалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн хүрээнд тухай бүр цахимаар зарлан хуульд нийцүүлэн нээлтэй ил тод байх зарчмыг баримтлан ажилласан.

5. Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-15.2.6-д заасан Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд хэрэгжүүлсэн ажлуудаас дурдвал:

5.1. Бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт https://erp.e-mongolia.mn/ шилжүүлэн бичгийн цаас, хувилагч, хэвлэгч хорны зардлыг хэмнэсэн.

5.2. Байгууллага нэгдсэн халаалтын системд холбогдсон, цахилгаан эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэн ажилтан албан хаагчдад компьютер болон ажлын техник хэрэгслээ унтрааж явах, усаа хэмнэх уриалга гарган ажилласан. Мөн Улаанбаатар хот орчимд дахин дамжуулах гачуурт, шархад, Дархан-Уул аймгийн Дархан хотын дахин дамжуулах сайтын байрны эрчим хүчний хэрэглээний тоолуурыг ухаалаг (смарт) болгон шинэчилсэн.

5.3. Манай байгууллага нь орон нутгийн 5 салбараар дамжуулан Монгол Улсын бүх сум сууринд өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаар Төрийн нэрийн өмнөөс тасралтгүй хэрэгжүүлдэг үндэс чиг үүргийнхээ хүрээнд томилолтын зардал их гардаг байсныг хэмнэж, орон нутгийн салбаруудтай цахимаар холбогдож, сургалт, уулзалт хурал, заавар зөвлөгөө өгөх зохион байгуулалтыг хийж хэвшсэн.

"Төрийн хэмнэлтийн хууль"-ийн хүрээнд дээрх зардлуудыг хэмнэн ажиллаж, цөөн чанартай боловсон хүчнээр байгууллыг орон тоог бүрдүүлэн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулан, хэмнэж болох зардлыг тооцсны дагуу зардлыг багасган ажиллаж байна.

ЗАХИРАЛ Ж.ЭНХБАТ

МОНГОЛ УЛСЫН
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Нэгдсэн үндэстний гудамж 5,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 15 53, Факс: 32 86 34,
Цахим шуудан: info@mlsp.gov.mn
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

2024.11.29 № 01/14.30

танай 2024.11.14 -ны № ХЭГ/2816 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгатай холбогдуулан салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг нэгтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 4.. хуудастай.

Л.ЭНХ-АМГАЛАН

· 15424111S

D: 2024 on 11 sar A5

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн
хамгааллын сайдын 2024 оны
...11..дүгээр сарын 29...-ны
өдрийн 01/1120 дугаар албан
бичгийн хавсралт

1. **Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсөд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангасан эсэх;**

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бусад ажилчдын цалин хөлс олгохтой холбоотой гомдол мэдээллийн дагуу хийсэн хяналт шалгалтаар ажилтны үндсэн цалин, илүү цаг, шөнийн цагийн нэмэгдэл хөлсийг хууль тогтоомжид заасны дагуу бодож олгодоггүй зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 5 хуулийн этгээдэд нийт 1032 ажилтны 7,396,742.0 мянган төгрөгийн үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг нөхөн олгуулах улсын ахлах байцаагчийн акт хүргүүлсэн.

Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиг үүрэг 2023.01.01-ний өдрөөс Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шилжин ирсэн. 2023-2024 онд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захиралд олгох цалин хөлс, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой болон гэрээнд тусгасан нөхцөлүүдийн хэм хэмжээг тайлбарлахтай холбоотой 1 гомдол ГБХНХЯ-ны Салбарын хяналтын газарт ирсэн байна. Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой болон гэрээнд тусгасан нөхцөлүүдийн хэм хэмжээг тайлбарлахтай холбоотой асуудлаар Хөдөлмөрийн тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.2-т заасны дагуу компаний хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисст хандаж урьдчилан шийдвэрлүүлэх хариу хүргүүлсэн.

2. **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3. Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална" гэж заасны дагуу нийтлэг жишиг батлагдсан эсэх, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгсэлд хэрхэн хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан тухай;**

Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-ийг салбарын хэмжээнд баримтлан ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газраас төрийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 2022-2024 онд 96 байгууллагын 328 ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд хэмжилт шинжилгээ, 1 м^3 агаарт хөгц мөөгөнцөр илрүүлэх шинжилгээг хийж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартууд болон Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-тэй харьцуулан Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн 40 дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажилласан.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт шинжилгээгээр 103 ажлын байрны агаарт буюу 31.4 хувьд нь хөгц мөөгөнцөр илэрсэн. Нийт ажлын байрны 178 буюу 54.2 хувь нь Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг"-т заасан эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэлд ногдох талбай хэмжээнд хүрэхгүй байна. Хүснэгт 1.

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Он	Хэмжилт хийсэн өрөөний тоо	Шаардлага хангаагүй өрөөний тоо	Хөгц мөөгөнцөр илэрсэн өрөөний тоо
1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	2022	12	0	-
2	Орхон аймаг ЭБЦТС ТӨХК	2022	8	2	6

3	Орхон аймгийн Төрийн тусгай хамгаалалтын газар	2022	6	2	4
	Дүн		26	4	
1	Орхон аймаг ЭБЦТС ТӨХК	2023	10	0	10
2	Орхон аймаг Стандарт хэмжил зүйн хэлтэс /лаборатори/	2023	8	3	5
3	Баян-Өлгий аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгаллын газар	2023	5	5	-
4	Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар	2023	9	9	Тааз, хана шаланд хөгц мөөгөнцөр үүссэн.
	Дүн		32	17	
1	ШУТИС-ийн Гадаад хэлний сургууль	2024	1	1	-
2	Хүүхэд, гэр бүл хөгжил хамгаллын ерөнхий газар	2024	4	0	Таазанд хөгц мөөгөнцөр үүссэн
3	Эрүүл мэндийн яам	2024	18	6	7
4	Архангай аймгийн Дотоодын цэргийн 831-р түсгай анги	2024	4	1	Харуулын байр
5	Ховд аймгийн Цэргийн гавьяаны одонт Цагдаагийн газрын Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байр	2024	2	2	-
6	Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс /лаборатори/	2024	8	1	7
7	Орхон аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс	2024	1	1	-
	Дүн		38	12	14
	Нийт		96	33	14

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэсэн заалтын хэрэгжилт;

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагуудын ажилтан, албан хаагчид дүрэмт хувцас худалдан авахтай холбоотой зардал улсын төсөвт тусгагддаггүй бөгөөд Төрийн хэмнэлтийн хуулийн үйлчлэлийн хүрээнд дүрэмт хувцас хэрэглээгүй, худалдан аваагүй болно.

Улсын төсвийн нормын хувцас худалдан авах зардлын ангилалд улсын төрөлжсөн асрамжийн /Ахмад настны үндэсний төв, Өнөр бүл хүүхдийн төв/ байгууллагуудын үйлчлүүлэгчдэд олгох нормын хувцас болон Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор, Сэргээн засалт сургалт, үйлдвэрлэлийн төв, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн зөөлөн эдлэл болон эмч, эмнэлгийн ажилтнууд, байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай үйлчилгээний ажилтнуудын нормын хувцас зэргийг олгож байна.

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" гэсэн заалтын хэрэгжилтийн тухай;

Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд харьяа агентлаг, төсөвт байгууллагад чиглэл хүргүүлж ажилласан.

Засгийн газрын 2023 оны "Процессын дахин инженерчлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 419 дүгээр тогтоолын хүрээнд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас Хөдөлмөр, нийгмийн хамгаллын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын зарим агентлагт хийсэн процессын дахин инженерчлэлийн санал, дүгнэлтийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгаллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, тэдгээрийн харьяа салбар, нэгжийн хүрээнд процессын дахин инженерчлэлийг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгаллын яамны стратеги, бүтэц, орон тоог шинэчлэн тогтоож, Нийслэлийн Нийгмийн даатгалын хэлтсийг татан буулгаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны А/51, А/52, А/53 дугаар тушаалаар бүтэц, орон тоог шинэчлэн баталж давхардлыг арилгасан бөгөөд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, харьяа байгууллагуудын бүтэц, орон тоог оновчтой болгох ажил хийгдэж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар Засгийн газрын агентлаг тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосонтой холбогдуулан 2022 оны 06 дугаар сард тус яамны харьяа агентлаг,

байгууллагуудын дэд даргыг ХНХСайдын тушаалаар ажлаас чөлөөлсөн бөгөөд харьяа байгууллагууд дээрх хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагууд хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй, хөрөнгөөр архи согтууруулах ундаа, бэлэг дурсгалын зүйл худалдан аваагүй худалдан аваагүй бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн үйлчлэлийн хүрээнд нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлын төсөв тусгагдаагүй болно.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.3 дахь заалт, Засгийн газрын 2022 оны "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203 дугаар тогтоолын дагуу сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулав.

Бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөөгүй бөгөөд төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд бараа үйлчилгээний зардлын төсөв бууруулж, сүүлийн жилүүдэд Сангийн яаманд төсөвлөж хүргүүлдэг хэдий ч өмнөх жилийн төсвөөр батлагддаг тул хангамжийн бараа материал нөөцлөх боломжгүй байсан.

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Нийгмийн халамжийн болон Нийгмийн даатгалын үйлчилгээнүүдийг "Цахим Монгол" хөтөлбөрийн хүрээнд нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлсэн.

Энэ хүрээнд 2023 онд Нийгмийн халамжийн 68 үйлчилгээг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн. Ингэснээр иргэд https://e-mongolia.mn/services/citizen/sector/all, ehalamj.mn https://www.ehalamj.mn цахим хуудас, төрийн үйлчилгээний цахим машин "ТҮЦ" машин, ebarimt https://ebarimt.m n/ аппликэйшн ашиглан нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлтээ гаргаж, үйлчилгээг бүрэн авах боломжтой болсон. Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах ажилд тусгайлан зардал гаргаагүй бөгөөд үйлчилгээг цахимжуулснаар иргэдийн ажил, эдийн засгийг хэмнэх тодийгүй улсын төсвийн хөрөнгөөр маягт хэвлүүлэх болон банкны үйлчилгээний хураамжийн зардлууд хэмнэгдээд байна.

Төсвийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1-р зүйлийн 4.1.6.сахилга баттай байх; 4.1.9.хариуцлагатай байх; 4.2-ийн 4.2.1 -т зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах; 15.2.3-т сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх гэсэн заалтуудыг үндэслэн уг зардалд 30.5 сая төгрөгийг зарцуулж уг зардлыг 83.8 хувиар буюу 157.9 сая төгрөгийг хэмнэсэн.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар "Хүнсний эрхийн бичиг олгох" журам шинэчлэгдэн батлагдсантай холбогдуулан "Халамжаас хөдөлмөрт" ажлын хүрээнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай иргэдийг журмын заалтыг биелүүлээгүй тохиолдолд хүнс тэжээлийн үйлчилгээнээс түдгэлзүүлэх, зогсоох арга хэмжээ авч ажилласан. Энэхүү журмын хүрээнд 2021 оноос 2022 оны 12 сар хүртэл нийт 17,333 өрхийн 97,648 иргэн хасагдсантай холбоотойгоор уг зардлыг 3,317.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн цахим худалдан авалтын хэрэгжилт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр зохион байгуулагдан хэрэгжихээр төлөвлөгдсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 100 хувь цахим системээр гүйцэтгэсэн ба үр дүн, гэрээ байгуулагдсан эсэх талаарх мэдээллийг цаг тухайд tender.gov.mn/mn цахим системд мэдээлэн мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулиар батлагдсан 2023 онд шинээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний Худалдан авах төлөвлөгөөг боловсруулан цахим системээр хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаа.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэлтэй төлөвлөгөөгөө байршуулсан 46 харьяа байгууллага, агентлагуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг илгээсэн цаг хугацаанд нь хянан баталгаажуулан, хуульд заасан хугацаанд төлөвлөгөө боловсруулан байршуулах тухай болон бүртгэлгүй байгаа сайдын багцын байгууллага тус бүрд холбогдох зөвлөмж чиглэлийг амаар болон бичгээр өгч ажилласан. Худалдан авах ажиллагааны цахим системээр төлөвлөгөө болон төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах хүсэлтээ ирүүлсэн 32 байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 56 төлөвлөгөөний өөрчлөлт хийсэн хүсэлтийг хянан баталгаажуулсан байна. Нийт салбарын хэмжээнд 177 тендер шалгаруулалт зохион байгуулагдахаар төлөвлөгдөн тендер. мн цахим системд мэдээлэгдсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй болно.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэмнэлт 737.4 сая төгрөгийг зарцуулаагүй болно.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд 15,332.4 сая төгрөг, барьцаанд 1,004.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай 19 төсөл арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг ханган ажилласан.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг ханган ажиллаж гүйцэтгэлийн санхүүжилтийг олгож ил тод нээлттэй байдлыг хангаж ажилласан.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД

Засгийн газрын XIV байр, Чингисийн өргөн чөлөө,
Хан-Уул дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 30 51, Факс: (976) 7004 3479,
Цахим шуудан: info@energy.gov.mn

2024.11.29 № а/3824

танай 2024.11.14 -ны № ХЭГ/2216 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын дагуу дараах хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хувийг Сангийн яаманд.

Хавсралт 1.. хуудастай.

Б.ЧОЙЖИЛСҮРЭН

Эрчим хүчний сайдын 2024 оны
11 дүгээр сарын 27-ны өдрийн
А/138 дугаартай албан бичгийн хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН О.ЦОГТГЭРЭЛЭЭС
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД
ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Төрийн хэмнэлтийн хуулийн
хэрэгжилтийн талаар

Асуулга 6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2-т заасан Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн цахилгаан, дулааны эрчим хүчний хэрэглээг хэмнэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлууд, гарсан үр дүн тоо, чанараар, нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулсан эсэх, тоолуурын тоо, гарсан үр дүн тоо, чанараар;

Короновируст халдвар /COVID-19/-ын цар тахлын хөл хорио тогтоосон үед Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 182 дугаар тогтоолоор Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн эрчим хүчний жилийн хэрэглээний босго хэмжээг тогтоосноор тухай онд 129 хэрэглэгчид үүрэг хүлээлгэж дараах үр дүнд хүрсэн болно.

Хүснэгт 1

Хэрэгжүүлсэн арга хэмжээ, төслийн үр дүн						
Он	ҮХХ-ийн тоо	Хэрэгжүүлсэн ажлын тоо	Зарцуулсан хөрөнгө оруулалт сая төг	ЭХХэмнэлт		CO_2 ялгарлын бууралт
				мян.кВт.ц	сая төг	мян.тонн
2019	129	866	-	68,512.4 (44.6)*	4,917.7	69.5
2020	211	925	41,657.7	96,484.6 (1.4)*	11,984.0	78.1
2021	197	1075	44,582.3	74,867.6 (28.2)*	27,797.8	67.6
2022	197	947	39,530.4	18,972.8 (41.3)*	10,829.0	31.0

*Дулааны эрчим хүчний хэмнэлт, мян.Гкал

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 67 дугаар тогтоолоор үүрэг хүлээсэн хэрэглэгчийн босго хэмжээг шинэчлэн баталсанаар үүрэг хүлээсэн хэрэглэгчийн тоог 279-д хүргэж, 2023 онд 16.9 сая кВтц цахилгаан эрчим хүч, 60.8 мянган Гкал дулааны эрчим хүчийг тус тус хэмнэж, 4.4 тэрбум төгрөгийн хэмнэлтийг хийсэн байна. /Хүснэгт 2-ыг харна уу/

Үүрэг хүлээсэн 279 хэрэглэгчээс 42 нь төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, 13 нь төсвийн байгууллага байна. Эдгээр байгууллагууд нь Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 2023 онд тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлснээр 7.5 сая кВт.ц буюу 1.6 тэрбум төгрөгийн цахилгаан эрчим хүч, 59.7 мянган Гкал буюу 153.9 сая төгрөгийн дулааны эрчим хүчний хэмнэлтийг хийсэн байна. /Хүснэгт 3-ын харна уу/

Хүснэгт 2

№	Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн ангилал	Зарцуулсан зардал (сая төг)	2023 онд хэмнэсэн эрчим хүч			
			мян. кВт.ц	сая төгрөг	мян. Гкал	сая төгрөг
А. Барилга байгууламж өмчлөгч ҮХХ -65						
А.1.	Төрийн болон орон нутгийн төсөвт байгууллага -13	595.0	515.0	116.4		
А.2.1.	Бусад иргэн хуулийн этгээд /худалдаа оффис/ -47	1,427.3	168.0	38.0		
А.2.2.	Үйлчилгээ -5	109.0	38.3	8.7		
		2,131.3	721.3	163.0	-	-
Б. Эрчим хүч хэрэглэгч ҮХХ -172						
Б.3.	Уул уурхай (олборлолт, боловсруулалт) -31	19,940.0	5,468.0	1,701.0	0.8	85.2
Б.4.1.	Хүнд үйлдвэр -31	350.0	1,394.0	68.0	0.4	41.2
Б.4.2.	Дунд / Хүнсний үйлдвэр -46	1,041.0	745.0	149.0		
Б.4.3.	Хөнгөн үйлдвэр -42	2,660.0	281.0	252.0	0.0	0.1
Б.5.	Мэдээлэл, холбоо -6	1,053.0	205.0	83.0		
Б.6.	Бусад -16	2,366.0	1,110.0	231.0		
		27,410.0	9,203.0	2,484.0	1.1	126.5
В. Эрчим хүчний үйлдвэрлэл, дамжуулалт, түгээлтийн үйл ажиллагаа эрхлэгч ҮХХ -42						
В.7.	Эрчим хүч үйлдвэрлэгч -25	4,545.7	2,821.6	634.6	8.9	66.3
В.8.	Эрчим хүч дамжуулагч -3	981.7	784.6	114.1		
В.9.1.	Цахилгаан түгээгч, хангагч -10	16,545.0	3,296.3	734.6		
В.9.2.	Дулаан түгээгч, хангагч -4	9,397.9	52.0	12.0	50.8	87.6
		31,470.4	6,954.5	1,495.3	59.7	153.9
	НИЙТ	61,011.7	16,878.8	4,142.4	60.8	280.5

Хүснэгт 3

№	Үүрэг хүлээсэн хэрэглэгчийн ангилал	Зарцуулсан зардал (сая төг)	2023 онд хэмнэсэн эрчим хүч			
			мян.кВт.ц	сая төгрөг	мян.Гкал	сая төгрөг
1	Төрийн болон орон нутгийн төсөвт байгууллага -13	595.0	515.0	116.4		
2	Төрийн өмчит хуулийн этгээд -42	31,470.4	6,954.5	1,495.3	59.7	153.9
	Нийт	32,065.4	7,469.5	1,611.7	59.7	153.9

Цахилгаан эрчим хүчний төлбөрийг хэрэглэгчдээс бодит хэрэглээгээр буюу тоолуураар тооцож авдаг. Харин дулааны эрчим хүч буюу хэрэглэгчдийн халаалтын төлбөрийг халаалтын улирлын үргэлжлэх хугацаанд сар бүр тогтмол задгай хэмжигдэхүүнээр буюу метр квадрат болон метр кубээр тооцож байгаа болно.

Дулааны эрчим хүчний төлбөрийг бодит хэрэглээгээр тооцох зорилгоор аймгийн төвүүд, томоохон хотуудын дулааны эрчим хүчийг тоолуураар тооцох тарифыг баталсан ба дулааны тоолуур тавиулах хүсэлт гаргасан барилгын дотор халаалтын системийн шаардлага хангасан хэрэглэгч бүрийг тоолууржуулах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллаж байна.

Барилгын дотор халаалтын системийн шаардлага хангахгүй хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний төлбөрийг дулааны зардал хуваарилах (heat cost allocator) төхөөрөмжөөр тооцох зорилгоор хууль, эрхзүйн орчныг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Улаанбаатар хотын төсөвт байгууллагын 843 хэрэглэгчдээс 80 хувь нь дулааны тоолууртай, 20 хувь нь дулааны тоолуургүй, бусад 17 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 24 хувь нь дулааны тоолууртай, 76 хувь нь дулааны тоолуургүй байна. Айл өрхийн 294 мянган хэрэглэгчдээс 0.5 хувь нь дулааны тоолууртай, 99.5 хувь нь тоолуургүй байна.

Өөрөөр хэлбэл, төсөвт байгууллагын 12 сая метр куб эзлэхүүнээс 98 хувийг тоолууpаар, 2 хувийг тоолуургүй, аж ахуйн нэгж, байгууллагын 48 сая метр куб эзлэхүүнээс 87 хувийг тоолууpаар, 13 хувийг тоолуургүй, айл өрхийн 19 сая метр квадрат талбайгаас 1.4 хувийг тоолууpаар, 98.6 хувийг задгай хэмжигдэхүүнээр буюу тоолуургүй тооцож байна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД

Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай 3,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 61 71, Цахим шуудан: contact@met.gov.mn,
Цахим хуудас: www.mecc.gov.mn

2024.11.28 № 01/5680

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Н.УЧРАЛ ТАНАА

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгын хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 3 хуудастай.

С.ОДОНТУЯА

1524000088

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны
өөрчлөлтийн сайдын 2024 оны 11 дүгээр
сарын 28-ны өдрийн А/568 дугаартай
албан бичгийн хавсралт

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

№	Хуулийн заалт	Хэрэгжилт
1	7.3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.	Засгийн газрын чиг үүрэг.
2	8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно.	Энэ заалтын дагуу байгаль хамгаалагчаас бусад албан хаагчдад дүрэмт хувцас худалдан авааг үй болно.
	8.2.Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй.	
3	10.1.Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.	Яам болон харьяа байгууллагууддад ажиллагсдыг цалинг Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын дагуу тогтоон олгож байна.
4	14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	Салбарын хэмжээнд жил бүр тогтмол худалдан авдаг бараа, ажил, үйлчилгээний байдаггүй тул санал хүргэгдээгүй болно.
	14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ.	
	14.3.Төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ирүүлсэн хүсэлтэд үндэслэн холбогдох бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт оруулах арга хэмжээг тухай бүр хийж гүйцэтгэнэ.	Төрийн худалдан авах ажиллагааны газрын чиг үүрэг.
	14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно.	Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авах худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй болно.
	14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах	Төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг тухай бүр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

	худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.	тухай хуулийн дагуу цахим системд нээлттэйгээр зохион байгуулан ажилласан болно.
5	15.1.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.1.Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэргүйгээр шинээр хараат болон охин компани байгуулах;	Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэргүйгээр шинээр хараат болон охин компани байгуулаагүй болно.
	15.1.2.чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох;	Засгийн газрын 2024 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай" 06 дугаар тогтоолын дагуу бүтцээр, орон тооны хязгаараас хэтрүүлэлгүйгээр ажиллаж байна.
	15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;	Хууль тогтоомжид зааснаас бусад тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй болно.
	15.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлээгүй болно.
	15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах;	Хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
	15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;	Хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
	15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах үндаа худалдан авах.	Хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
6	15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана: 15.2.1.байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;	Байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэн ажиллаж байна. Эхний 11 сарын байдлаар цахилгааны төсөв 29.6 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 16.3 сая төгрөг төлж 13.3 сая төгрөг, цэвэр усны төсөв 5.5 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 3.2 сая төгрөг төлж 2.3 сая төгрөг, дулааны төсөв 12.2 сая төлөвлөгдсөнөөс 4.5 сая төгрөг төлж 7.7 сая төгрөг тус тус хэмнэсэн.
	15.2.2.нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;	Тус яам Засгийн газрын байрны захиргааны байранд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тус байр нэгдсэн тоолуурт холбогдсон.
7	17.1.Засгийн газар хэмнэлтийн талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 17.1.1.чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх;	Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн "Зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар" батлах тухай" 06 дугаар тогтоолын дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/329 дүгээр тушаалаар яамны албан тушаалын жагсаалт, ангилал, зэрэглэлийг батлан, 9 газар, 10 хэлтэс, 1 ажлын алба, нийт 122 хүний орон тоотой, шинэ нэршил, шинэ бүтцээр ажиллаж байна. Аялал жуулчлалын чиг үүрэг,

		орон тоо нь Соёл, спорт, залуучуудын яаманд шилжих болсонтой холбоотойгоор өмнөх бүтэц /129/-ээс 7 орон тоо хасагдсан.
	17.1.2.төр, олон нийтэд үзүүлж байгаа үйлчилгээний орлогоор өөрийгөө санхүүжүүлэх боломжтой төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газруудыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулах, тухайн чиг үүргийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх;	Засгийн газрын 2024 оны 213 дугаар тогтоолын дагуу Хустайн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны үүргийг "Хустайн цогцолборт газар төв" төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр 10 жилийн хугацаагаар гүйцэтгүүлэх гэрээг 11 сард байгуулсан.
	17.1.3.төрийн зарим нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх;	
	17.1.4.төрийн байгууллагын орон тоо, цалин хөлсний төлөвлөлт, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох;	Засгийн газрын 2024 оны "Тогтоолд хавсралт нэмэх, тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай" 84 дүгээр тогтоол, мөн 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолын дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоож олгож байна.
	17.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх.	Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу https://pimis.publicinvestment.gov.mn цахим системээр тус хуулийн заалтыг баримтлан төлөвлөж байна.
	17.2.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын чиг үүрэг.
8	20.2.Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд, сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулна.	Тус яамны харьяа 3 улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга нар нь үүрэг гүйцэтгэгчээр томилогдсон тул төрийн албаны салбар зөвлөл хуралдаж гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах зарыг тавьж сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод, нээлттэй байршуулахаар хүлээгдэж байна.

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

120

МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 35 06,
Цахим шуудан: info@mimr.gov.mn,
Цахим хуудас: www.mimr.gov.mn

2024.11.27 № 01/1134
танай 2024.11.14 -ны № ам/2216 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс тавьсан асуулгын дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах дараах мэдээллийг хүргүүлж байна.

Үүнд:

1. Хуулийн 7.3-т "Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална" гэсэн заалт нь тус яамны чиг үүрэгт хамаарахгүй байна. Тавилга хэрэгсэл, өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар шинэчлэн томилсон бөгөөд тус зөвлөл нь байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгийг ашиглалтын талаар тухай бүр санал дүгнэлт гарган шийдвэрлүүлж байна.

2. Хуулийн 8.1, 8.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т "Улсын байцаагч нь хянан шалгах үүргээ гүйцэтгэхэд шаардагдах хөдөлмөр хамгааллын хувцас болон техник хэрэгслээр хангагдах эрхтэй" гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тус яаманд шилжиж ирсэн 11 улсын байцаагчийг 1,148,400 төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцсаар хангасан. Байгууллагын ажилтан, албан хаагчдад байгууллагын болон төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авааагүй болно.

3. Хуулийн 10.1-д "Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно" гэсэн заалт нь тус яамны чиг үүрэгт хамаарахгүй байна.

4. Хуулийн 14.1 дэх заалт буюу цахим худалдан авалтын хэрэгжилтийн хүрээнд:

- Засгийн газрын 2022 оны 203 дугаар "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" тогтоолын 4 дэх хэсэгт заасны дагуу Үүл уурхай,

1500 05 1154

хүнд үйлдвэрийн (хуучин нэрээр) сайдын багцын хэмжээнд цахим дэлгүүрт оруулан, ерөнхий гэрээгээр худалдан авах боломжтой бараа, үйлчилгээний тоо хэмжээ, нэгж үнийн саналыг боловсруулан 2022.08.19-ний 01/2254 тоот албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-т "цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 2022 онд 12,2 сая төгрөгийн 3ш, 2023 онд 26,9 сая төгрөгийн 10ш бараа, үйлчилгээг цахим дэлгүүрээс гэрээ байгуулан худалдан авсан.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.5-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэж заасны дагуу хуульд заасан босго үнээс давсан бүх худалдан авах ажиллагааг 100% цахимаар зарлан, зохион байгуулж ажилласан.

5. Хуулийн 15 дугаар зүйл буюу хэмнэлтийн бусад арга хэмжээний талаарх зүйл заалтуудыг мөрдлөг болгон ажилласан.

6. Хуулийн 15.2-т заасан байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх ажлын хүрээнд Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газартай гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтийг жил бүрийн эцэст дүгнэн, акт үйлдэж, зардлыг бууруулах чиглэлийг баримтлан ажилласан.

7. Хуулийн 17 дугаар зүйл буюу "Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ"-ний хүрээнд тус яаманд тусгайлан хариуцуулан хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй болно.

8. Хуулийн 20.2 дахь заалтад хамаарах төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудсанд "нээлттэй мэдээлэл" цэсэд ил тод байршуулсан болно.

САЙД Ц.ТУВААН

МОНГОЛ УЛСЫН СОЁЛ,
СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН САЙД

Яамны байр, Денверийн гудамж,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14190
Утас: 26 56 26, Факс: (976-51) 26 56 26
Цахим шуудан: info@moc.gov.mn,
Цахим хуудас: www.moc.gov.mn

2024.11.27 № 1/1182

танай _____-ны № ХЭГ/2216 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танай 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн ХЭГ/2216 тоот албан бичигтэй танилцан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг хүргүүлж байна.

Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавих зорилгоор баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг дараах байдлаар хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:

1.Хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасныг хангаж, Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор баталсан өрөө талбайн хэмжээ дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгслийн нийтлэг жишгийн баримтлан ажиллаж байгаа бөгөөд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам 130 орон тоо батлагдсан бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа ажлын байр 1196.6 мк талбайтай, нэг албан хаагчид 9.2 мк талбай оногдож байна.

2.Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2 дахь заалтын хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нормын хувцас, зөөлөн эдлэл эдийн засгийн ангилалд төсөв тусган батлаагүй бөгөөд төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас аваагүй, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан.

3.Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтын хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 484 байгууллагуудын албан хаагчид "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол, бусад хууль тогтоомжийн хүрээнд цалин хөлс, нэмэгдэл тооцон олгож байна.

4.Хуулийн 14 дүгээр заалтын хэрэгжилтийн ханган Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 2024 онд цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээнээс 655 ширхэг 1,793.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалт хийсэн. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах сонгон шалгаруулалт tender.gov.mn сайтаар хийгдэж байна.

5.Хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтын хүрээнд Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу нийт байгууллагуудын цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, үндсэн үйл ажиллагаа, харуул хамгаалалт, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлуудаас бусад зардлуудыг

14190000000

шаардлагатай тушаал шийдвэр болон холбогдох бичиг баримтыг хавсарган Сангийн яамаар зарцуулалтын эрх, санхүүжилтийг нээлгэн зарцуулж байна. Сайдын багцын 49 байгууллага 2023 онд цахилгаан дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг батлагдсан төсвөөс 121.4 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласан.

6.Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөр, ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардал, зочин төлөөлөгч хүлээн авах, гадаад томилолтын зардал, банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж, арга хэмжээг 2023-2025 онуудын төсөвт тусгаагүй бөгөөд ном хэвлэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, норматив зардал, эд хогшил, урсгал засварын зардлыг батлагдсан төсвийн хязгаарт багтаан өр, авлага үүсгэхгүй санхүүжүүлсэн.

7.Мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалтын хэрэгжилтийн ханган "Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын захирлын сонгон шалгаруулалтыг 2023 оны 03 дугаар сард олон нийтэд нээлттэйгээр зарлан зохион байгуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн "Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын захирлыг томилох тухай" 310 дугаар тушаалаар Б.Түмэн-Өлзийг томилсон.

Ч.НОМИН

124

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 23 50,
Цахим шуудан: info@pcsp.gov.mn,
Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2024.11.22 № А-1/2034

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгатай холбогдуулан эрхлэх асуудлын хүрээнд хамаарах мэдээллийг бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 7 хуудастай

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

137008608

А-4/2024

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 20[illegible] оны 11 сарын 22-ны өдрийн
А-1/[illegible] тоот албан бичгийн хавсралт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Хуулийн 7.3-р заалтын хэрэгжилтийн талаар:

Дээрх хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоолын 2 заалтаар "Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах санал"-ыг боловсруулж Засгийн газрын хуралдаанаа хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны А/54 дүгээр тушаалаар холбогдох байгууллагын (ЗГХЭГ, СЯ, ЗТХЯ, ТӨБЗГ, Барилгын хөжлийн төв, Стандарт, хэмжил зүй газар) албан тушаалтнуудаас бүрдсэн "Төрийн албан хаагчийн унаа, өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгслийн нийтлэг жишиг"-ийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулан ажилласан.

Тус ажлын хэсэг өөрийн болон гадаад улс орнуудын төрийн үахиргааны байгууллагын албан ажлын өрөө тасалгааны нийтлэг жишиг, стандартын талаар судалж үзэхэд доорх байдалтай байна.

1.БНХАУ-ын төрийн захиргааны байгууллагын албан ажлын өрөө, тасалгааны нийтлэг жишиг, стандартын журамд зааснаар:

- Сайд 54 м.кв
- Дэд сайд 42 м.кв
- Газрын дарга 24 м.кв
- Хэлтсийн дарга 18 м.кв
- Ахлах мэргэжилтэн12 м.кв
- Мэргэжилтэн 9 м.кв
- Туслах ажилтан 9 м.кв

2.Бүгд найрамдах Турк Улсын төрийн захиргааны албанд ажиллагсдын өрөөний стандартын дүрэмд зааснаар:

- Төрийн захиргааны удирдах дээд албан тушаалтан 80-100 м.кв
- Төрийн захиргааны дунд шатны удирдах албан тушаалтан 12-80 м.кв
- Төрийн захиргааны ахлах мэргэжилтэн 12 м.кв
- Төрийн захиргааны мэргэжилтэн 9 м.кв
- Төрийн захиргааны туслах ажилтан 6 м.кв

3.Бүгд найрамдах Болгар Улсын төрийн албан хаагчид ноогдох талбай хэмжээний тухай журамд зааснаар:

- Сайд 56-70 м.кв

- Дэд сайд 42-56 м.кв
- Салбар хорооны дарга 30-42 м.кв
- Төрийн захиргааны дээд албан тушаалтан 12-30 м.кв
- Төрийн захиргааны ахлах мэргэжилтэн 9-12 м.кв
- Төрийн захиргааны үндсэн ажилтан 6-9 м.кв

4.Оросын холбооны Улсын захиргаа, нийтийн албан тушаалын өрөө, тасалгааны нийтлэг жишиш, стандартын журамд зааснаар:

- Нэгдүгээр удирдах албан тушаалтан 25 м.кв
- Хоёрдугаар удирдах албан тушаалтан 20 м.кв
- Гуравдугаар удирдах албан тушаалтан 15 м.кв
- Нэгдүгээр зөвлөх 25 м.кв
- Хоёрдугаар зөвлөх 15 м.кв
- Гуравдугаар зөвлөх 9 м.кв
- Ахлах мэргэжилтэн 15 м.кв
- Мэргэжилтэн 9 м.кв
- Туслах ажилтан 7.5 м.кв

5.Бүгд найрамдах Казакстан Улсын захиргаа болон нийтийн албан тушаалтан дагаж мөрдөх өрөөний талбанй хэмжээ, нормативын тухай дүрэмд зааснаар:

- Сайд 54 м.кв
- Дэд сайд 42 м.кв
- Яамны Төрийн нарийн бичгийн дарга 20 м.кв
- Нийслэл Астана хотын удирдах албан тушаалтан 25 м.кв
- Алма-Ата хотын удирдах албан тушаалтан 20 м.кв
- Мужийн дэсийн удирдах албан тушаалтан 15 м.кв
- Ахлах мэргэжилтэн 15 м.кв
- Мэргэжилтэн 9 м.кв
- Туслах мэргэжилтэн ба төрийн үйлчилгээний ажилтан 7.5 м.кв байна.

<u>Монгол Улсад мөрдөгдөж буй дүрэм, журмыг судалж үзэхэд:</u>

1.Засгийн газрын 2002 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн "Зардлын эорматив, нийтлэг жишиг батлах тухай 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэслийн нийтлэг жишгийг дараах байдлаар баталсан байна.

- Тэргүүн түшмэл болон түүнтэй адилтгах албан тушаалтан 36 м.кв
- Эрхэлсэн түшмэл болон түүнтэй адилтган албан тушаалтан 24 м.кв
- Ахлах түшмэл болон түүнтэй адилтгах албан тушаалтан 8 м.кв
- Дэс түшмэл болон түүнтэй адилтгах албан тушаалтан 8 м.кв
- Төрийн үйлчилгээний удирдах албан хаагч 24 м.кв

2.Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн "Барилгын дүрэм батлах тухай" 198 дугаар тушаалаар захиргааны зориулалттай олон нийтийн барилгын дүрмийг баталсан.

Уг дүрмээр байгууллагын удирдлагын ба хүлээлгийн өрөөний талбай хэмжээг:

Зориулалт	Талбай, м.кв, (байгууллага дахь хүмүүсийн тооноос хамаарна)			
	100-300	300-600	600-1000	1000-аас дээш
Байгууллагын удирдах албан тушаалтны өрөө, тасалгаа	27-36	300-600	45-54	54
Нэгдүгээр орлогчийн өрөө тасалгаа	18-24	24-36	24-36	36-45
Орлогчийн өрөө	12-18	18-24	18-24	18-36
Даргын туслахын өрөө (референт)	12	12	12	12-18
Байгууллагын удирдлагын хүлээлгийн өрөө	12	18	24	36
Орлогчийн хүлээлгийн өрөө	12	12	18	24

Ажлын өрөөнүүдийн талбайг:

- Хэлтсийн дарга, ерөнхий мэргэжилтэн, ерөнхий нягтлангийн ажлын өрөөний талбайн хэмжээ 9 м.кв,
- Хэлтсийн даргын орлогч 7.5 м.кв,
- Инженер, эдийн засагч, нягтлан, зааварлагч 6.5 м.кв
- Бичээч, бичиг хэргийн ажилтан 5м.кв
- Хуульч, аж ахуйн үйлчилгээний ажилтан, нийгмийн ажилтан 9 м.кв

3.Стандарт, хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2001 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй, эргономикийн ерөнхий шаардлага MNS 5027:2001 стандарт нь дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй харьцан ажилладаг сургалт, мэдээллийн төв, ажлын байрны төлөвлөлт, зохион байгуулалтын эрүүл ахуй, эргономикийн ерөнхий шаардлагыг тогтоож, ажилтны ажил амралтын горимыг зөв зохион байгуулах, хөдөлмөрийн тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх, ядралтаас урьдчилан сэргийлэх, ажилтны эрүүл мэндийг хамгаалах, ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилготой стандартыг баталсан. Үүнд:

1. Ажлын байрыг төлөвлөх, тоног төхөөрөмжийг байрлуулахад тавих шаардлага.
2. Ажлын байрны бичил уур амьсгал, агааржуулалтад тавих шаардлага.
3. Шуугиан, доргион
4.Гэрэлтүүлэг
5. Статистик цахилгааны хамгаалахад тавих шаардлага
6. Ажлын байрны зохион байгуулалт

7. Ажил амралтын горим зэргийг тогтоосон байна.

ТӨБЗГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 3 удаа хуралдаж, холбогдох дүрэм, стандарттай танилцсаны үндсэн дээр дараах санал, дүгнэлтийг гаргасан байна. Үүнд:

1. Засгийн газрын яам, агентлагуудын байрлаж буй байр, талбайн судалгаанаас харахад 1 албан хаагчид ногдох талбайн хэмжээ 5-39 м.кв байгаа бөгөөд гадаад улстай харьцуулахад харьцангуй бага м.кв, гэвч Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсан тул түүнийг нэмэгдүүлэх боломжгүй юм.

2. Байгууллага албан хаагчийн ажлын чиг үүрэг, онцлогоос хамаарч ижил хэмжээ, загварын өрөө, талбай, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгсэлтэй байх боломжгүй байна. Тухайлбал: Зарим байгууллагын албан хаагчид заалны зохион байгуулалтаар сууж иргэдэд үйлчилгээ үзүүлдэг, зарим албан хаагчид өөрсдийн албан өрөөндөө ажлаа гүйцэтгэх шаардлагатай болдог.

3. Захиргааны албан хаагчдын удирдлагын болон аж хуйн нэгжийн албадын байр, хурлын заал, мэдээлэл-техникийн өрөө, нийгэм ахуйн үйлчилгээний өрөө, техникийн үйлчилгээний өрөөний хэмжээ, гэрэлтүүлэг, агааржуулалтын талаар нарийвчлан тогтоосон дүрэм, стандарт байгаа тул шинээр дүрэм, стандарт боловсруулах шаардлагагүй бөгөөд харин шинээр захиргааны байр барихдаа энэхүү дүрэм, стандартын хатуу чанд мөрдөж байх;

Иймд Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолоор батлсан албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэн хуучин журмыг мөрдлөг болгон хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Хуулийн 10.1-р заалтын хэрэгжилтийн талаар:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн "Журам батлах тухай" 184 дүгээр тогтоолоор "Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам"-ыг батлсан. Тус журмын 2 дугаар хавсралтаар "Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирлын албан тушаалын сарын хөдөлмөрийн хөлс тогтоох аргачлал"-ыг баталж, аргачлалын дагуу харьяа 41 төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн захирлын жишиг цалинг тогтоон, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Хуулийн 20.2-р заалтын хэрэгжилтийн талаар:

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяа 41 компани, үйлдвэрийн газруудын Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийн төлөөллийн гишүүд болон хараат бус гишүүн, Гүйцэтгэх захирлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.2-р заалт, Засгийн газрын 2023 оны 84, 85-р тогтоолоор батлсан журмын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж үр дүнг ТӨБЗГ болон тухайн байгууллагуудын цахим хуудсанд нээлттэй ил тод байршуулсан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын харьяанд буй компаниудын хувьд 2022 онд 36, 2023 онд 33, 2024 онд 12 хараат бус гишүүдийг тус тус холбогдох хууль, тогтоомж, журмын хүрээнд томилсон байна.

№	Он	ТӨБЗГ-ын харьяа компанийн тоо	Үүнээс ТУЗ-тэй компанийн тоо	ТУЗ-д төрийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүн	ТУЗ-ийн хараат бус гишүүн
1	2022	26	14	86	36
2	2023	25	13	80	33
3	2024	7	6	31	12

Хуулийн хүрээнд ТӨБЗГ-ын харьяа дараах үйлдвэрийн газар, компанийн захирал нарыг хууль тогтоомжийн хүрээнд сонгон шалгаруулж, үр дүнг ТӨБЗГ-ын болон тухайн байгууллагын цахим хуудсанд байршуулж ажилласан. Үүнд:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 454 дүгээр тогтоолоор “Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв” ТӨҮГ-ын захирлаар М.Амгаланбаатарыг томилсон.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 484 дүгээр тогтоолоор “Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төв" ТӨҮГ-ын захирлаар Ж.Чойхандыг томилсон.

3. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 382 дугаар тогтоолоор "Мэдээлэл, технологийн үндэсний парк" ТӨҮГ-ын захирлаар Ж.Золзаяаг томилсон.

4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 381 дүгээр тогтоолоор "Дархан АЗЗА" ТӨХК-ын гүйцэтгэх захирлаар Б.Батболдыг томилсон.

5. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 373 дугаар тогтоолоор "Монголын төмөр зам" ТӨХК-ын гүйцэтгэх захирлаар Б.Отгонсүхийг томилсон.

6. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 310 дугаар тогтоолоор "Монгол кино нэгтгэл" ТӨХК-ын гүйцэтгэх захирлаар Б.Түмэн-Өлзийг томилсон.

7. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор "Булган АЗЗА" ТӨХК-ын гүйцэтгэх захирлаар М.Нуваантуяаг томилсон.

8. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 278 дугаар тогтоолоор "Говь-Алтай АЗЗА" ТӨХК-ын гүйцэтгэх захирлаар Б.Алтанхуягийг томилсон.

9. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 277 дугаар тогтоолоор "Увс АЗЗА" ТӨХК-ын гүйцэтгэх захирлаар Р.Төмөрчөдөрийг томилсон.

10. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 161 дүгээр тогтоолоор "Төрийн орон сууцны корпораци" ТӨХХК-ын гүйцэтгэх захирлаар Б.Эрдэнэбулганыг томилсон.

11. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 157 дугаар тогтоолоор "Эрдэнэсант АЗЗА" ТӨХК-ын гүйцэтгэх захирлаар А.Баясгаланг томилсон.

12. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 13 дугаар тогтоолоор "Багануур А33А" ТӨХК-ын гүйцэтгэх захирлаар М.Мягмаржаргалыг томилсон.

13. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолоор "Дорноговь А33А" ТӨХК-ын гүйцэтгэх захирлаар У.Баярбилэгийг томилсон.

14. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 3 дугаар тогтоолоор "Геологийн судалгаа шинжилгээний төв" ТӨҮГ-ын захирлаар Д.Мөнхбаатарыг томилсон.

Хуулийн 6.1-р заалтын хэрэгжилтийн талаар:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.1 дэх заалтын дагуу суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа төрийн өмчийн авто тээврийн хэрэгслийг Засгийн газрын авто бааз, Авто тээврийн үндэсний төв, Цагдаагийн байгууллага, Татварын байгууллагатай хамтран татан төвлөрүүлж ажилласан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нийт 242 автомашиныг "Засгийн газрын автобааз" УТҮГ болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын авто гражид хүлээн авч, автомашин бүрийг үзлэгт оруулан, төлбөр, торгууль, чанар байдлыг шалган актаар баталгаажуулан хүлээж авсан.

Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсанаас хойш Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хандан УИХ-ын гишүүд, төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, аймаг, сумдын Засаг дарга нараас нийт 1053 автомашин шилжүүлэн авах хүсэлт ирүүлсэн.

Татан төвлөрүүлсэн автомашинаас эхний ээлжид Төрийн тусгай хамгаалалтын газар болон Засгийн газрын Автобаазад шилжүүлж, дуудлагын үйлчилгээнд ашиглуулахаар шийдвэрлэсэн бөгөөд дараагийн ээлжид Төрийн хэмнэлтийн хуулийн 6.4-д заасан байгууллага, эрүүл мэндийн байгууллага, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газарт шилжүүлэх шийдвэрийг гаргаж ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын газар, түүний 21 аймаг дахь газруудыг татан буулгасан тул тухайн хөрөнгийг орон нутагт нь ялангуяа автомашин шаардлагатай байгаа байгууллагад нь шилжүүлэх зарчмаар 53 автомашиныг тухайн байгууллагуудад урьдчилан үзүүлж, чанар байдлыг шалгаж шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн 486 нэрийн нийт 24,5 тэрбум төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг татан төвлөрүүлж 136 автомашиныг төрийн өмчийн данс бүртгэлээс хасч, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд бүртгэх, 159 автомашиныг Төрийн хэмнэлтийн хуулийн 6.5-д төрийн өмчит байгууллагад шилжүүлж, 191 автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах шийдвэрийг гаргуулж ажиллалаа.

Хэмнэлтийн хуульд заасан бусад арга хэмжээний хэрэгжилтийн талаар:

- Төрийн өмчит үйлдвэрийн газар, компанийн нийт 104 тэргүүн дэд, дэд, орлогч захирлыг чөлөөлж 4,405,775.29 мянган төгрөг

- Төрийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлох, орон тоо, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн баталснаар 5,678,216.49 мянган төгрөг,
- Сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт, хэвлэл захиалга, удирдлагын харилцаа холбооны зардал болон бусад зардлыг хэмнэх, спорт баяр ёслол, хурал семинар, ой тэмдэглэх зэрэг нийтийн арга хэмжээг санхүүжүүлэхгүй байхаар заасны хүрээнд 26,167,493.34 мянган төгрөг хэмнэсэн.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

---oooOOOooo---

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2024.11.25 № 05-3/380

танай _____-ны №_____-т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Н.УЧРАЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танаас ирүүлсэн 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн ХЭГ/2216 тоот албан бичигтэй танилцлаа.

Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгад харьяа байгууллагуудаас гаргасан мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт 10 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД Т.ДОРЖХАНД

000244007307

133

ЗАСГИЙН ГАЗАР
УЛСЫН ОРОЛЦООТ АЖЛЫН ГАЗАР
Засгийн газрын 11 дүгээр байр, Сүхбаатарын талбай
17 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: 7656 1717 (факс)
И-мэйл хаяг: info@mfa.gov.mn
Цахим хуудас: www.mfa.gov.mn

2024.11.22 № 01/157

2024.11.15 № Х/1265

МОНГОЛ УЛСЫН ШАДАР
САЙДЫН АХЛАХ ЗӨВЛӨХ
БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА З.ЛХАГВАДОРЖ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд тавьсан асуулга дахь мэдээллийг хүргүүлж байна.

1. ЗГХЭГ-аас өгсөн чиглэлийн дагуу Баянзүрх дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө 16А хаягт байрлах Засгийн Газрын 9 дүгээр байрны 7 дугаар давхарт байрлаж байна. Агентлагийн орон тоо 30, байрны нийт талбайн хэмжээ 350 мкв.
2. Тус агентлаг нь албан хэрэгцээнд дүрэмт хувцас ашигладаггүй.
3. Засгийн Газрын 2024 оны 128 дугаар тогтоолыг мөрдөн ажиллаж байна.
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дүгээр зүйлд заасны дагуу хэмнэлтийн бусад арга хэмжээг авч ажиллаж байна.
6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн дагуу цахилгаан, дулаан, цэвэр усны хэрэглээг зохистой ашиглах талаар анхаарч ажиллаж байна. Тус агентлаг нь И-Монгол академийн ERP систем нэвтрүүлж, албан хэрэг хөтлөлт, албан харилцааг бүрэн цахим хэлбэрт шилжүүлсэн.

Асуулгын 7, 8 дугаар зүйлүүд тус агентлагт хамааралгүй болно.

Хөрөнгө оруулалт, худалдааны газар
Удирдлага
Дарга
Воршилов Энхбаатар
2024-11-22 16:36:38

134

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРӨНГӨ ГАЗАР

МОНГОЛЫН ЭРДЭС ГАЗАР

ШАДАР САЙДЫН АХЛАХ ЗӨВЛӨХ
БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА
З.ЛХАГВАДОРЖ ТАНАА

Тус газарт ирүүлсэн 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Х/1265 тоот "Мэдээлэл ирүүлэх тухай" албан бичигтэй танилцаж хариуг хүргүүллээ.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА Б.БИЛГҮҮН

135

Монополын эсрэг газрын Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн биелэлт

№	Шалгуур үзүүлэлт /Хуулийн заалт/	Хуулийг хэрэгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
1	7 3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 52 дугаар тогтоолоор 627.4 м2 байранд 36 албан хаагч 20 өрөөнд ажиллах захирамж гарсан.
2	8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно. 8.2.Энэ хуулийн 8 1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 15.1-д заасан тусгай хувцас хамаарахгүй.	Тус газар нь тайлан онд албан хаагчдад дүрэмт хувцас худалдан аваагүй.
3	10 1.Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.	Чиг үүрэгт хамааралгүй заалт
4	14.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.	Тус газар нь тайлант онд худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/https.//www tender.gov.mn/-ээр зохион байгуулсан
	14.2.Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ	Тус газар нь тайлант онд худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/https://www.tender gov.mn/-ээр зохион байгуулсан
	14.3.Төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ирүүлсэн хүсэлтэд үндэслэн холбогдох бараа	Тус газар нь тайлант онд худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим

136

	үйлчилгээг цахим дэлгүүрт оруулах арга хэмжээг тухай бүр хийж гүйцэтгэнэ.	систем/https://www.tender.gov.mn/-ээр зохион байгуулсан.
	14.4.Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно. 14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана	Тус газар нь тайлант онд худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем/https://www tender gov.mn/-ээр зохион байгуулсан.
5.	15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана: 15.2.1.байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх; 15.2.2.нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;	Тус газар нь Засгийн газрын 9 дүгээр байранд байрладаг бөгөөд ЗГБНҮГазарт гэрээний дагуу байр ашиглалтын үйлчилгээний төлбөр төлдөг.
6	17.1.1.чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх;	Чиг үүрэгт хамааралгүй заалт
	17.1.2.төр, олон нийтэд үзүүлж байгаа үйлчилгээний орлогоор өөрийгөө санхүүжүүлэх боломжтой төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газруудыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулах, тухайн чиг үүргийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх;	Чиг үүрэгт хамааралгүй заалт
	17.1.3.төрийн зарим нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх;	Чиг үүрэгт хамааралгүй заалт
	17.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх.	Тайлант онд тус газарт хөрөнгө оруулалтын зардал батлагдаагүй болно.
	17.2.Энэ хуулийн 6 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэхтэй холбогдсон нийтлэг журмыг Засгийн газар батална.	
7	20.2.Энэ хуулийн 3.1.3, 3 1 4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, гүйцэтгэх захирлыг нээлттэй сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийн ажлын байранд тавих шаардлага, сонгон шалгаруулалтад оролцсон этгээд сонгон шалгаруулалтын үнэлгээний тайлан, томилсон шийдвэрийг олон нийт танилцах боломжтой хэлбэрээр байгууллагын цахим хуудсанд ил тод нээлттэй байршуулна	Чиг үүрэгт хамааралгүй заалт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Вэбхуудас: www.spa.gov.mn

2024.11.08 № А-Ц/4408

танай 2024.11.15 -ны № Х/1265 -т

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
Т.ДОРЖХАНД ТАНАА

Танай 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Х/1265 дугаартай албан бичиг тэй танилцлаа.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс ирүүлсэн 31 тоот асуулгад тус газарт холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт: ... хуудастай.

ДАРГА Ц.БАТЗУЛ

Төрийн Худалдан авах ажиллагааны
газрын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны
өдрийн А-1/4408 дугаартай албан
хавсралт

ТАНИЛЦУУЛГА

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 зүйл, цахим худалдан авалтын хэрэгжилтийн талаарх мэдээлэл

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 зүйл, Цахим худалдан авалтын хэрэгжилтийн талаарх мэдээллийг 2022, 2023, 2024 он тус бүрээр боловсруулан хүргүүлж байна.

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2-т "худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ" гэж заасан хүрээнд:

Төрийн хэмнэлтийн тухай хууль 2022 онд батлагдсан тул 2023, 2024 онуудад 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт ирүүлсэн захиалагчийн мэдээллийг хүргүүллээ.

№	Агуулга	2023 он	2024 он
1.	Хүсэлт ирүүлсэн захиалагчийн тоо	29	31
2.	Хүсэлтийн тоо	52	36
3.	Бараа, үйлчилгээний нэр төрөл /давхардсан тоогоор/	1,178	1,752

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 58 аж ахуй эрхлэгчтэй 358 нэр төрлийн бараа, үйлчилгээ нийлүүлэх 575 ерөнхий гэрээ байгуулж, бараа, үйлчилгээг Цахим дэлгүүрт байршуулсан.

Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээний нэр төрөл нэмэгдүүлэх хүсэлтийг 2023 онд 29 захиалагчаас ирүүлсэн бол 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 31 захиалагч ирүүлсэн байна.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.3-т "төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь ирүүлсэн хүсэлтэд үндэслэн холбогдох бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт оруулах арга хэмжээг тухай бүр хийж гүйцэтгэнэ"-ийн гэж заасан хүрээнд:

№	Агуулга	2022 он	2023 он	2024 он
1.	Зохион байгуулсан төсөл, арга хэмжээний тоо	14	14	6
2.	Зохион байгуулсан тендер шалгаруулалтын тоо	28	29	10
3.	Цахим дэлгүүрт бүртгэсэн бараа, үйлчилгээний нэр төрөл	122	222	113
4.	Ерөнхий гэрээ байгуулсан бараа нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн тоо	38	255	240
5.	Нийт ерөнхий гэрээний тоо	214	690	593

Захиалагчийн хүсэлтээр цахим дэлгүүрт байршуулах бараа, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх тендер шалгаруулалтыг Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулдаг бөгөөд 2022 онд 14 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж 122 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээ Цахим дэлгүүрт бүртгэж, 38 аж ахуй эрхлэгчтэй 214 ерөнхий гэрээ байгуулсан бол 2023 онд 222 нэр төрлөөр бараа, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, 255 захиалагчтай 690 ерөнхий гэрээ байгуулсан байна.

2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нийт 6 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалт зохион байгуулж, 113 нэр төрлийн бараа, үйлчилгээ нийлүүлэх 240 аж ахуй эрхлэгчтэй 593 ерөнхий гэрээ байгуулсан байна.

Ерөнхий гэрээний хүчинтэй хугацааг 3 хүртэл жилээр байгуулахаар хуульчилсан байдаг. Иймээс Ерөнхий гэрээний хүчинтэй хугацаа дуусаагүй 315 бараа, үйлчилгээ нийлүүлэх 273 аж ахуй эрхлэгчийн 1005 ерөнхий гэрээний хүчинтэй байна.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4-т “цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэж заасан хүрээнд:

№	Агуулга	2022 он	2023 он	2024.11.20 хүртэл
1.	Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авсан захиалагчийн тоо /ТЕЗ/	37	48	55
2.	Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авсан захиалагчийн тоо	990	1,163	991
3.	Цахим дэлгүүрээр бараа, үйлчилгээ худалдсан бараа нийлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн тоо	59	174	205

4.	Цахим дэлгүүрээс худалдан авсан бараа, үйлчилгээний нэр төрөл /давхардаагүй тоо/	213	310	357
5.	Цахим дэлгүүрээс худалдан авсан бараа, үйлчилгээний тоо ширхэг	302.2 сая	64.3 сая	78.3 сая
6.	Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ нийлүүлэх захиалгын гэрээний тоо	21.1 мянга	31.4 мянга	37.2 мянга
7.	Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авахаар захиалга хийсэн захиалгын нийт дүн	115.9 тэрбум	1.4 их наяд	408.7 тэрбум
8.	Цахим дэлгүүрээс бараа, үйлчилгээ худалдан авсан захиалгын гэрээний дүн	101.3 тэрбум	813.2 тэрбум	301.5 тэрбум
9.	Гэрээний хэмнэлт	14.7 тэрбум	589.01 тэрбум	107.2 тэрбум

Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс 2022 онд хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах 990 захиалагч байгууллагаас 213 нэр төрлийн бараа, үйлчилгээг 101.3 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна.

Ерөнхий гэрээ нэгж үнийн дээд хязгаараас хоёр дахь шатны сонгон шалгаруулалтын дагуу худалдан авсан нийт үнэ буюу 14.7 тэрбум төгрөгийн хэмнэлт үүссэн бол энэ үзүүлэлт 2023,2024 онд өссөн үзүүлэлттэй байна.

4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.5-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана" гэж заасан хүрээнд:

№	Агуулга		2022 он	2023 он	2024.11.20 хүртэл
1.	Тендер шалгаруулалт зохион байгуулсан ТЕЗ		57	57	61
2.	Тендер шалгаруулалт зохион байгуулсан захиалагч		1,368	1,683	1,914
3.	Зохион байгуулсан тендер шалгаруулалтын тоо		13,406	13,505	16,359
4.	Цахим системээр	Тендер шалгаруулалт зохион байгуулсан захиалагч	1354	1,664	1,897
		Зохион байгуулсан тендер шалгаруулалтын тоо	13,287	13,338	16,233

		Нийтэлсэн урилга	24,410	22,932	29,844
		Төсөвт өртөг	24.8 их наяд	20.6 их наяд	39.2 их наяд
5.	Уламжлал бүюу цаасан хэлбэрээр тендер хүлээн авсан	Тендер шалгаруулалт зохион байгуулсан захиалагч	33	32	28
		Зохион байгуулсан тендер шалгаруулалтын тоо	136	167	132
		Нийтэлсэн урилга /Цахим системд/	163	209	208
		Төсөвт өртөг	329.6 тэрбум	465.4 тэрбум	1.4 их наяд
6.	Цахим системд нийтэлсэн нийт урилгын тоо		24,573	23,141	30,052
7.	Нийт төсөвт өртөг		25.14 их наяд	21.04 их наяд	40.5 их наяд

2022 онд:

Захиалагч тендер шалгаруулалт бүрийн урилга, үр дүнг цахим сүлжээнд тухай бүр зарлахаар хуульчилсан.

Монгол Улсын Засгийн газраас төрийн болон орон нутгийн төсвийг үр ашигтай захиран зарцуулах, худалдан авах ажиллагааг хурдан шуурхай, олон нийтэд хүртээмжтэй, ил тод, нээлттэй зохион байгуулах, түүнд олон нийтийн хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ийг боловсруулан 2017 оноос бүх шатны төрийн байгууллагуудхудалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа ашиглаж байна.

Худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт 100 хувьд хүрээд байна.

Түүнчлэн Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу 583.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 184 төсөл арга хэмжээ, Дэлхийн банкны худалдан авах ажиллагааны журмын дагуу 108.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 205 төсөл арга хэмжээ, ХБНГУ-ын Сэргээн босголт, зээлийн банкны журмын дагуу 20.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл арга хэмжээний урилгыг цахим системээр дамжуулан зарласан байна.

Тайлант хугацаанд захиалагч цахим системээр давхардсан тоогоор 24,573 урилга нийтэлсэн байна.

2023 онд:

Тайлант хугацаанд 209 тендер шалгаруулалтыг уламжлалт хэлбэрээр зохион байгуулахаар зарлаж, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д урилга нийтэлсэн байна.

2023 онд нээлттэй тендер шалгаруулалтын 52 хувь, тендер шалгаруулалтын онцгой журмаар зарласан тендер шалгаруулалтын 27 хувь дахин зарлагдсан байна.

Цахим системд нийтэлсэн урилгын мэдээллийг хүснэгтээс үзэхэд 2023 онд 13,505 тендер шалгаруулалтыг давхардсан тоогоор 23,141 урилга нийтэлснээс 22,232 үр дүн буюу 96 хувийг цахим системд нийтэлж, шалгарсан оролцогчийн тендерийг бусад оролцогчдод ил болгосон байна.

Үр дүнгийн 4 хувь нь тендер шалгаруулалт амжилтгүй болж дахин зарлагдсантай холбоотой байна.

2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар:

Тайлант хугацаанд 132 төсөл, арга хэмжээний 208 тендер шалгаруулалтыг уламжлалт хэлбэрээр зохион байгуулахаар зарлаж, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д урилга нийтэлсэн байна.

Цахим системд нийтэлсэн урилгын мэдээллийг хүснэгтээс үзэхэд 2024 онд 61 төсвийн ерөнхийлөн захирагчийн 1,914 захиалагч 16,359 тендер шалгаруулалтыг урилгыг давхардсан тоогоор 30,052 удаа нийтэлсэн байна.

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР

143

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД
Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15
Цахим шуудан: info@mrt.gov.mn
Цахим хуудас: www.mrt.gov.mn

2024.12.04 № 01/2012 хэг/2216

-ны №

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Таны 2024 оны "Асуулгын хариу бэлтгүүлэх тухай" ХЭГ/2216 дугаар албан бичгээр ирүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийн асуулгад эрхлэх асуудлын хүрээнд хамаарах мэдээллийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 9 хуудастай.

"ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ"
УДИРДЛАГА
САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН
2024.12.04 18:19

C0001454

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХАНГАМЖ, ЗАРИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

5 дугаар зүйл.Дэд, орлогч дарга

5.1.Хуульд тусгайлан заагаагүй бол төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг Засгийн газрын агентлаг, Засгийн газрын ажлын алба, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага, эмнэлэг, төрийн болон орон нутгийн өмчийн их сургууль, төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компаниас бусад этгээд тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглоно.

Хуульд нийцүүлэн хасагдсан орон тооны жагсаалт

№	Байгууллага	Тоо	Тайлбар
1.	Иргэний нисэхийн ерөнхий газар	1	Дэд дарга
2.	Автотээврийн үндэсний төв ТӨҮГ	4	Дэд захирал
3.	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	1	Дэд захирал
4.	МТЗ ТӨХК	4	Дэд захирал
5.	МИАТ ТӨХК	4	Үйлдвэрлэл эрхэлсэн тэргүүн дэд захирал, Захиргаа, хууль эрх зүй эрхэлсэн дэд захирал, Коммер эрхэлсэн дэд захирал, Санхүү эрхэлсэн дэд захирал
6.	Зүүнбаян төмөр зам ХХК	3	Дэд захирал
7.	Тавантолгойн төмөр зам ХХК	3	Дэд захирал
8.	Нийт	20	

5.3.Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно.

Хуульд нийцүүлэн хасагдсан орон тооны жагсаалт

№	Байгууллага	Тоо	Тайлбар
1.	Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ	1	Зөвлөх
2.	МТЗ ТӨХК	3	Төрийн болоод байгууллагын харилцаа харицсан зөвлөх, 2.Санхүү хуулийн асуудал хариуцсан зөвлөх, 3.Төмөр замын асуудал хариуцсан мэргэжлийн зөвлөх
3.	Нийт	4	

5.4.Энэ хуульд заасныг зөрчиж дэд дарга, тэргүүн дэд дарга, орлогч, зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно.

6 дугаар зүйл.Тээврийн хэрэгсэл

6.1.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

*Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 656 дугаар тогтоолын дагуу яам нь 5 автомашин ашиглахаас 4 автомашин ашиглаж байна.

№	Хамаарагдах албан тушаалтан	Тээврийн хэрэгслийн улсын дугаар	Тээврийн хэрэгслийн загвар	Тээврийн хэрэгслийн өмчлөгч	Зориулалт
1.	Зам, тээврийн хөгжлийн сайд	1016 УНҮ	Хьюндай Соната ЛФ-8	ЗТХЯ	Хот доторх замын хөдөлгөөнд
2.	Зам, тээврийн хөгжлийн яам	0151 УБЗ	Ниссан патрол Y62	ЗТХЯ	Орон нутгийн томилолтод
3.	Зам, тээврийн хөгжлийн яам	4278 УНҮ	Тоёота Ланд Крузер-200	ЗТХЯ	Орон нутгийн томилолт, албан хэрэгцээнд
4.	Зам, тээврийн хөгжлийн яам	5675 УНҮ	Тоёота Hiace	ЗТХЯ	Орон нутгийн томилолт, албан хэрэгцээнд

6.3.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн автотээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.

6.4.Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.

6.5.Дараах байгууллагад энэ хуулийн 6.3 дахь хэсэг хамаарахгүй:

6.5.1.эмнэлгийн тусламж үйлчилгээ;

6.5.2.гамшгаас хамгаалах алба;

6.5.3.цагдаагийн алба;

6.5.4.байгаль орчныг хамгаалах алба;

6.5.5.зэвсэгт хүчин, хилийн ба дотоод цэрэг;

6.5.6.тусгай алба;

6.5.7.гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх алба;

6.5.8.дипломат алба;

6.5.9.шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба;

6.5.10.хот тохижилт, нийтийн аж ахуйн үйлчилгээ;

6.5.11.гаалийн албa;

6.5.19.үндсэн үйл ажиллагаа нь төрийн ёслолын болон шуурхай албаны, тусгай зориулалтын автотээврийн хэрэгсэл ашиглах хэрэгцээ, шаардлагыг бий болгодог бусад байгууллага.

/Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдгийн стандарт болон Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-д холбогдох өөрчлөлт орсны дагуу зам, тээврийн салбарын албан хэрэгцээнд ашигладаг авто тээврийн хэрэгслүүд бүгд тод цэнхэр өнгийн дэвсгэртэй улсын дугаар ашиглаж байна./

7 дугаар зүйл.Албан тасалгаа

7.1.Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар ашиглах боломжгүй болохыг тогтоосон тухай эрх бүхий байгууллагын дүгнэлт, шийдвэр гарснаас бусад тохиолдолд захиргааны зориулалтаар барилга шинээр барихыг хориглоно.

7.2.Энэ хуулийн 7.1 дэх хэсэг нь хот төлөвлөлтийн арга хэмжээнд хамаарахгүй.

7.3.Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална.

Нэг. Зам, тээврийн хөгжлийн яамны Сайд, Дэд Сайд, ТНБД-ын өрөөний м/кв жагсаалт:

Сайд: 57 м/кв

Дэд сайд: 41 м/кв

ТНБД: 51 м/кв

Хоёр. Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн албан ажлын унаа, өрөөний талбайн хэмжээ, тавилга, хэрэгслийн нийтлэг жишиг" журмын дагуу нэг албан хаагчид 8 ам метр ажлын өрөөний талбай ногдоно гэж заасан байдаг.

Гурав. Зам, тээврийн хөгжлийн яам нь нийт 145 албан хаагчтай бөгөөд Засгийн газрын 13 дугаар байр нь нийт албан тасалгааны 1,762.2 м/кв талбайтай үүнээс хурлын өрөө, сервир, дарга нарын өрөөг хасвал нийт 941.6 м/кв талбайтай бөгөөд 136 албан хаагчид хуваан тооцвол нэг албан хаагчид 7.4 м/кв талбай ноогдож байна.

8 дугаар зүйл.Дүрэмт хувцас

8.1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад-албан хаагч дүрэмт хувцас хэрэглэхийг хориглоно.

8.3.Энэ хуулийн 8.1-д эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас хамаарахгүй.

Тайлбар: Энэ зүйлд заасан "цэргийн албан хаагч" гэж зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээ,

авлигатай тэмцэх, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг ойлгоно.

9 дүгээр зүйл.Албан томилолт

9.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээд агаарын тээврийн хэрэгслээр албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчихыг хориглоно.

9.2.Энэ хуулийн 9.1-д заасан этгээд нэн тэргүүнд үндэсний агаарын тээвэрлэгчийг сонгож үйлчлүүлнэ.

9.3.Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.

/"Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдыг орон нутагт албан томилолтоор ажиллуулах журам"-ын төслийн Найм. Хяналт хариуцлага хэсгийн 8.3-т "Орон нутагт албан томилолтоор ажиллаж буй албан хаагч томилолтын удирдамж, төлөвлөгөөнд тусгагдаагүй чиглэлд заагдаагүй зорчихыг хориглоно" гэж заасан./

11 дүгээр зүйл.Нэг удаагийн мөнгөн тэтгэмж

11.1.Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй.

/Тус яамны хувьд Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын дагуу өндөр насны тэтгэвэрт гарахад 36 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгодог, давхардуулан мөнгөн тэтгэмж олгодоггүй болно./

14 дүгээр зүйл.Цахим худалдан авалт

14.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах тендер шалгаруулалтыг цахимаар зарлана.

/Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасны дагуу Зам, тээврийн салбарын худалдан авах ажиллагааг бүрэн цахимаар явуулж байна. Тухайн жилийн төсөв батлагдсан даруйд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллага бүрээр гарган, цахим систем tender.gov.mn-д нийтэлж, төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулан ажиллаж байна./

15 дугаар зүйл.Хэмнэлтийн бусад арга хэмжээ

15.1.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зүйлсийг хориглоно:

15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;

/Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид шагнал олгох журам, Төрийн албан хаагчид мөнгө урамшуулал олгох" журамд заасны дагуу урамшуулал, шагналыг олгож байна./

148

Зам, тээврийн сайдын 2024 оны
12 дүгээр сарын 04-ний өдрийн
01/2012 тоот албан бичгийн хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Хуулийн дугаар	ХУУЛИЙН ЗААЛТ	ХАРИУЦСАН НЭГЖ	ХУГАЦАА	ХЭРЭГЖИЛТ
7.3	"Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална." гэж заасны дагуу уг нийтлэг жиших батлагдсан эсэх, төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтны өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга хэрэгсэлд хэрхэн хяналт тавьж хуулийн хэрэгжилтийг хангасан талаар;	*Засгийн газар*	Хууль үйлчлэх хугацаанд	Зам, тээврийн салбарын хэмжээнд 2002 оны 120 дугаар тогтоолыг баримтлан ажиллаж байна. 2022-2023 онд салбарын хэмжээнд тавилга, тоног төхөөрөмж худалдан авалтыг Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу хязгаарлаж ажилласан. Албан хаагчдын ажлын байрны зураг авалтыг хийж, нэг албан өрөөнд нэг хэвлэгч, хувилагч байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.
8.1, 8.2	1.Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно. 2.Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, Зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас хамаарахгүй.	Зам, тээврийн салбар	Хууль үйлчлэх хугацаанд	2022-2023 онд төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авалт хийгээгүй. 2024 оны 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан хуулийн нэмэлт өөрчлөлтөөр "2.Энэ хуулийн 8.1-д Үндсэн хуулийн цэцийн гишүүний болон шүүгчийн өмсгөл, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, Зам тээврийн салбарын ажилтнуудын хуульд заасан тусгай хувцас хамаарахгүй." заалтыг батлагдсан.
14	Цахим худалдан авалт	Зам, тээврийн салбар	Хууль үйлчлэх хугацаанд	Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д заасны дагуу Зам, тээврийн салбарын худалдан авах ажиллагааг бүрэн цахимаар явуулж байна. Тухайн жилийн төсөв

149

				батлагдсан даруйд Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг байгууллага бүрээр гарган, цахим систем tender.gov.mn-д нийтэлж, төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг цахим системээр зохион байгуулан ажиллаж байна.
15	Хэмнэлтийн бусад арга хэмжээ 15.1.1.Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэргүйгээр шинээр хараат болон охин компани байгуулах; 15.1.2.чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох; 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; 15.1.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх; 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах; 15.1.6.нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх; 15.1.7.байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах. ~~15.2.3.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;~~ */Энэ заалтыг 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./*	Зам, тээврийн салбар	Хууль үйлчлэх хугацаанд	Зам, тээврийн хөгжлийн /хуучнаар/ сайдын төсөвт 2022 онд хөрөнгө оруулалтын зардал 450,8 тэрбум төгрөг, урсгал зардалд 14,3 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хууль батлагдсаны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 93 дугаар тушаалаар харьяа байгууллагуудыг төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх төлөвлөгөө гаргуулан урьдчилсан байдлаар тооцоо гаргаж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Энэ хүрээнд төсвөөс санхүүждэг 4 байгууллагын тухайд хөрөнгө оруулалтын зардлыг 292,8 тэрбум төгрөг, урсгал зардлыг 14,0 тэрбум төгрөг болгон тус тус бууруулж, 158,3 тэрбум төгрөгийн хэмнэлтийг 2022 онд гарган ажилласан. Харьяа байгууллагууд 11,4 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргах төлөвлөгөө гарган ажилласан. 2023 онд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах төсвийн төслийг боловсруулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хориглох зардлуудыг төсөвт тусгаагүй. Харин 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан хуулийн нэмэлт өөрчлөлтөөр зөвшөөрөгдсөн зардлуудыг 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг баримтлан холбогдох тогтоол, шийдвэрийн дагуу санхүүжүүлэн ажиллаж байна. Салбарын хэмжээнд

	15.2.4.бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэх; 15.2.5.хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх; 15.2.6.байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох. 15.3.Энэ хуулийн 15.1.4 -т заасан арга хэмжээ нь байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай шууд холбоотой бол тэдгээр арга хэмжээг хэмнэлтийн горимд хамааруулахгүй. */Энэ хэсэгт 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* */Энэ хэсэгт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./* 15.4.Энэ хуулийн 3.1.3, 3.1.4-т заасан хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирлын хооронд байгуулах гэрээ нь нэг жилийн хугацаатай байна. Гэрээнд заасан санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт бүрэн хангагдсан тохиолдолд гүйцэтгэх захирлын гэрээг үндсэн гэрээний хугацаагаар сунгаж болно.			1. Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэргүйгээр шинээр хараат болон охин компани байгуулаагүй. 2. Засгийн газрын тогтоол болон ТӨБЗГ, холбогдох дээд шатны байгууллагын гаргасач шийдвэрийн дагуу чиг үүрэг, орон тоог давхардуулахгүйгээр тогтоох зарчмыг баримтлан ажиллаж байна. Удирдлага, бүтэц зохиоч байгуулалт, орон тоо шинэчлэн баталж, Тэргүүн дэд захирал, Дэд дарга, дэд захирлуудын орон тоог хасч, нийт 20 албан хаагчийг үүрэгт ажлаас чөлөөлсөн. Нийт 20 3. Хууль тогтоомж, байгууллагын дотоод дүрэм, журамд зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй. 4. 2022-2023 онд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах төсвийн төслийг боловсруулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу хориглох зардлуудыг төсөвт тусгаагүй. Харин 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталсан хуулийн нэмэлт өөрчлөлтөөр /15.3/ зөвшөөрөгдсөн зардлуудыг 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй, үр ашигтай байх зарчмыг баримтлан холбогдох тогтоол, шийдвэрийн дагуу санхүүжүүлэн ажиллаж байна. /15.1.5-15.1.7, 15.2.4-15.2.6/ 5. Зам, тээврийн салбарын ТӨХК-ууд ТУЗөвлөл болон гүйцэтгэх захирлын томилгоог ТӨБЗГ-т санал өгөх байдлаар зохион байгуулж ирсэн ба байгууллага бүрийн цахим хуудасны Ил тод буланд энэ тухай мэдээллийг ил тод байршуулан ажиллаж байна. Холбогдох линк: https://www.miat.com/content20237.php?&lang=mn

15.2	15.2.Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана: 15.2.1.байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх; 15.2.2.нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах;	Зам, тээврийн салбар	Хууль үйлчлэх хугацаанд	Засгийн газрын 13-р байр болон харьяа өөрийн өмчийн байртай байгууллагууд бүрэн цахилгаан болон дулааны тоолууртай. Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд түрээсийн зардлыг 15-20 хувь бууруулан ажилласан. /15.2.1, 15.2.2/
17	Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ 17.1.1.чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах, бүтэц зохион байгуулалтыг өөрчлөх зэргээр удирдлагын зардлыг хэмнэх; 17.1.2.төр, олон нийтэд үзүүлж байгаа үйлчилгээний орлогоор өөрийгөө санхүүжүүлэх боломжтой төсөвт байгууллага, улсын үйлдвэрийн газруудыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулах, тухайн чиг үүргийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх; 17.1.3.төрийн зарим нийтлэг үйлчилгээг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх; 17.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилт нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар төлөвлөх.	Зам, тээврийн салбар	Хууль үйлчлэх хугацаанд	• Чиг үүргийн давхардалтай, эсхүл чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах байгууллага байхгүй. */17.1.1/ Харин УИХ-ын 2022 оны 16 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын 2023 оны 220 дугаар тогтоолоор Авто замын засвар арчлалтын ажил эрхэлдэг төрийн өмчит 20 компанийг нийлүүлэн "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК байгуулсан.* • Авто замын сангийн хөрөнгөөр олон улс болон улсын чанартай авто замын засвар арчлалтыг нийт 30 компаниар гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Үүнээс 20 ТӨХК нь Авто замын тухай хуулийн дагуу шууд гэрээгээр, 10 компани нь тендер зарлаж сонгон шалгаруулах журмаар шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байна. */17.1.2/* • БНХАУ-аас бусад улс руу зорчигч болон ачааны байнгын бус тээвэрлэлт хийх зөвшөөрлийн бичгийг олгох ажил, автотээврийн салбарын мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох сургалтын үйл ажиллагааг тус тус Монголын Автотээвэрчдийн нэгдсэн холбоогоор гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. */17.1.3/* • Монгол Улсын 2023, 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний саналыг боловсруулахдаа төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх,

				хянах, тайлагнах журам"-ын 3.3.4.2 дахь заалтын дагуу төлөвлөн УИХ, СЯ, УАГ-т тус тус хүргүүлсэн. */17.1.5/*

***Төрийн хэмнэлтийн тухай хуулийн заалт бүрээр 2022 онд гаргасан хэрэгжилтийг хавсаргав.**

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД

Засгийн газрын XI байр, Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 51-263333 Факс: 51-263333
Цахим шуудан: info@med.gov.mn
Цахим хуудас: med.gov.mn

2024.12.04 № 01/2636

танай _____-ны № _____-т

Г МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН Г
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Танай газраас ирүүлсэн ХЭГ/2216 тоот санал авах тухай албан бичигтэй танилцлаа.

Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт 2 хуудастай.

Эдийн засаг, хөгжлийн яам
Удирдлага
Монгол Улсын Тэргүүн Шадар сайд
бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд
Лувсанням Гантөмөр
2024-12-04 16:04:34

Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг,
хөгжлийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын ....
-ний өдрийн .... дугаар албан бичгийн хавсралт

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

1. Хуулийн 7.3 дугаар зүйл

Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 12 дугаар захирамжаар Засгийн газрын XI байрны 2,766.86 м2 талбайд Төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийг Засгийн газрын 2002 оны 120 дугаар тогтоолыг 1 дүгээр хавсралтад заасныг хангуулан ажиллаж байна.

2. Хуулийн 8.1, 8.2 дугаар зүйл

Төсвийн хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авалт хийгээгүй болно.

3. Хуулийн 10.1 дүгээр зүйл

Монгол Улсын Засгийн газрын 23 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд "Төр хувийн хэвшлийн түншлэлийн төв" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсан. Төрийн өмчийн бодлого төлөвлөлтийн газрын 428 дугаар тогтоолоор тус төвийн зохион байгуулалтын бүтцийг баталж, ТӨБЗГ-ын Авлигатай тэмцэх газрын 05/15858 дугаартай дүгнэлт,төвийн захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн захирлыг томилсон.

4. Хуулийн 14 дүгээр зүйл

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын IY.2.4.1-д заасан Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайдын багцад батлагдсан 40.0 тэр бум төгрөгийн эх үүсвэрийг Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/12, А/22 тоот тушаалаар, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/01, А/08, А/18, А/30 дугаартай тушаалаар нэмэлт өөрчлөлт хийж, нийт 39.9 тэр бум төгрөгийн төсөвт өртөг бүхий 78 төсөл, арга хэмжээг төлөвлөн, худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг цахим систем /www.tender.gov.mn/-ээр дамжуулан ТХААГ-т шилжүүлээд байна.

Төрийн худалдан авах ажиллагааны газрын мэдээгээр 11 дүгээр сарын 18-ны өдрийн байдлаар 11,750.7 сая төгрөгийн 33 төслийн гэрээ байгуулагдаж, 12,395.8 сая төгрөгийн 23 төсөлд гэрээ байгуулах эрх олгогдсон бөгөөд 4,393.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 4 төслийн тендерт үнэлгээ хийгдэн, 5,350.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 тендер зарлагдаад байна.

Нийт худалдан авах ажиллагааны төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 89.8 %-тай явагдаж байна. Монгол улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/03, А/32 тоот тушаал, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны А/03, А/04 тоот тушаалаар тус яамны үндсэн болон хөтөлбөр, арга хэмжээний урсгал зардлаар 2024 онд нийт 3,182.1 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 77 бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд үүнээс 3 нь нээлттэй тендер шалгаруулалт, 3 нь нэг эх үүсвэрээр, 19 нь харьцуулалт, 21 нь шууд худалдан авалт, 3 нь ерөнхий гэрээний аргаар зохион байгуулсан байна.

5. Хуулийн 15 дугаар зүйл

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн бусад арга хэмжээг хуулийн дагуу ханган ажилласан. Үүнд:

15.1.1. УИХ, ЗГ-ын газрын шийдвэргүйгээр шинээр хараат болон охин компани байгуулаагүй:

15.1.2.Ажилтан албан хаагчдын чиг үүрэг орон тоог давхардуулан тогтоогоогүй:

15.1.3 Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоогүй:

15.1.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын их хурлаас батлсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэрэгт санхүүжилт хийгээгүй:

15.1.5 Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын худалдан авалт хийгээгүй:

15.1.6 Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэж нөөцлөөгүй:

15.1.7 Байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авалт хийгээгүй:

15.2.1 Засгийн газрын 2014 оны 149 дүгээр тогтоолын 4 дэх заалт, Засгийн газрын 2003 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхэд баримтлах чиглэл"-ийг үндэслэл болгон Засгийн газрын байгууллагуудын нийтлэг үйлчилгээний газартай 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн ЭЗХЯ/77 тоот "Ажил, нийтлэг үйлчилгээ гүйцэтгэх тухай гэрээ" байгуулж хуваарийн дагуу зарцуулалтын гүйцэтгэл гаргасан:

6. Хуулийн 15.2 дугаар зүйл

Бичиг хэрэг албан хэтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд (office 365) цахим хэлбэрт шилжүүлэх зэргээр бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зардлыг хэмнэсэн.

Хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөргүй болно.

7. Хуулийн 17 дугаар зүйл

Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн 06 дугаар тогтоолоор яамны бүтэц зохион байгуулалт, орон тоог батлаж бүсчилсэн хөгжлийн бодлого, төлөөт бүс, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн чиг үүрэгт хамаарах баримт материал, албан хаагчдыг Монгол Улсын Шадар (бүсчилсэн хөгжил, онцгой байдлын асуудал эрхэлсэн) сайдын ажлын албанд шилжүүлсэн.

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 тогтоолыг мөрдөн ажиллаж байна.

8. Хуулийн 20.2 дахь заалт

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг, Монгол улсын Хөгжлийн банкны дүрмийн 8.4, 8.20 дахь хэсэг, Монгол улсын төргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн Б/22 дугаартай тушаал, Монгол Улсын Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн 28 тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилсон.

2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж 2022 оны 05 дугаар сарын 25 ны өдрийн "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 203 дугаар тогтоолын хүрээнд ШУА-ийн Ерөнхийлөгчийн зөвлөх болон ШУА-ийн орлогч дарга нарыг үүрэгт ажлаас бүрэн чөлөөлж тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэж олгосон байна.

156

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙД

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Багa тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-22-27, И-мэйл: letter@moe.gov.mn
Вэб сайт: moe.gov.mn

2024.12.10 № 1/2624
танай 2024.11.14 -ны № ХЭГ/2216 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Н.УЧРАЛ ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл, асуулгын хүрээнд хуулийн хэрэгжилтийн талаар дараах тайлбар, мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Хуулийн 7.3-т "төрийн албан хаагчийн албан ажлын өрөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, хэрэгслийн нийтлэг жишгийг Засгийн газар батална" гэж заасны хүрээнд мөрдөн ажиллаж байна.
2. Харьяа байгууллагууд нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8.1, 8.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэн төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авааг үй.
3. Боловсролын мэдээлэл технологийн төв нь Боловсролын сайдын батлсан цалин, бүтэц, зохион байгуулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд цалин хөлсийг тооцон олгодог. Бусад харьяа байгууллагууд нь Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын дагуу цалин хөлсийг тооцон төсөвтөө багтаан олгож байна. Санхүү, хөрөнгө оруулалтын газар нь чиг үүргийн хүрээнд харьяа байгууллагуудын цалин хөлс олголтод хяналт тавьж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
4. Боловсролын яамны харьяа байгууллагууд нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авалтын төлөвлөгөө гарган, 2023 онд нийт 1156, 2024 онд 1453 худалдан авах ажиллагааг цахим системд байршуулан, сонгон шалгаруулалт хийн ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгийн хэвийн ажиллагааг хангах хүрээнд бусад худалдан авалтыг цахим дэлгүүрт байршсан бараа үйлчилгээнээс сонгон авч, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 14.5 дахь заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.
5. Харьяа байгууллагууд нь бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийн цахим систем ашиглан, албан бичгээ цахимаар илгээн ажиллаж байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт хориглосон аливаа арга хэмжээг хэрэгжүүлээгүй.
6. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтын хүрээнд харьяа байгууллагууд нь 60вт-ын хуучин гэрэлтүүлгийг шинэ технологийн лед гэрлээр сольж, дунджаар 100 гэрлээс өдөрт 1.2квт, сард 360 квт цахилгаан хэмнэж байна. Мөн дулаан алдагдлыг бууруулж, барилгын цонхны хатуурсан резин, цуурсан шилийг солих, халаалтын хэмийг гаднах температураас хамаарч тохируулан, хэмнэлт үүсгэн ажиллаж байна.
7. Санхүү, хөрөнгө оруулалтын газар нь салбарын албан хаагчдын цалин,

урамшууллын санхүүжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн мэдээллийн санд хяналт хийж ажилладаг. Хяналтаар илэрсэн нэмэгдэл хөлсний үзүүлэлтэд салбарын албан хаагчдад хамааралгүй нэмэгдлийг баталгаажуулсан, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр шагнал, урамшуулал, дэмжлэг олгосон, нэмэгдэл хөлсийг холбогдох журамд заасан хувь хэмжээнээс илүү тооцож, цалингийн зөрүү бүрдүүлсэн зөрчлүүдийг арилгуулж, харьяа байгууллагуудад Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүллээ. Мөн салбарын сайдын баталсан орон тооны жишиг нормативыг чанд мөрдөн ажиллах, чиг үүргийн давхардал үүсгэхгүй байхыг анхааруулан хэрэгжүүлэн ажиллаж байна.

8. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20.2-д туссан арга хэмжээнд хамаарах хуулийн этгээд байхгүй болно.



П.НАРАНБАЯР